

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

## ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 - 53

1. *“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

7 - 53

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын 12-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Б.Баярбаатар;  
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан;  
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр.

**Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, ажлын хэсгийн зөвлөх У.Хосжаргал, Улсын Их Хурлын даргын зөвлөх Р.Алтангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг нар байлцав.

“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, С.Зулпхар, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, О.Номинчимэг, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, ажлын хэсгийн зөвлөх У.Хосжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, С.Зулпхар, О.Алтангэрэл нар үг хэлэв.

“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын Их Хурал стратеги, зорилт 2.

“Монгол Улсын Их Хурал үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжсэн цаг үеийн шаардлага, нийгмийн амин чухал эрэлт, хэрэгцээг тооцсон цогц шийдвэр гаргана” гэснийг “гаргах, институцийн чадавхыг бэхжүүлнэ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, С.Зулпхар нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	8
Бүгд:	15

46.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Стратегийн зорилт 3.

Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновац, технологийн “дэвшлийг дэмжинэ” гэснийг “дэвшлийг бүрэн нэвтрүүлнэ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, С.Зулпхар нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	13
Бүгд:	15

13.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Улсын Их Хурлын үнэт зүйлс хэсэгт “иргэдийн оролцоог хангах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	8
Бүгд:	15

46.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Улсын Их Хурлын үнэт зүйлс хэсэгт “иргэдийн оролцоог хангах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Монгол Улсын Их Хурлын үнэт зүйл хэсэгт “хамтын шийдвэрээ хүндэтгэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 13  
Бүгд: 15  
13.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Стратеги зорилт 2.3-ын “шаардлагыг” гэснийг “шаардлага, хуулийн хийдэл, зөрчлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 9  
Бүгд: 15  
40.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Стратеги зорилт 2.2 дээр “хяналт тавих” гэсний дараа “Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 8  
Бүгд: 15  
46.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 7  
Бүгд: 15  
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Стратеги зорилт 2.2 дээр “хяналт тавих” гэсний дараа “Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 7  
Бүгд: 15  
53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 6  
Бүгд: 15  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

---

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 45 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 04 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Мягмар гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
14 цаг 19 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаан оролцож байгаа гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Жадамбын Бат-Эрдэнэ, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн байна. Нямтайширын Номтойбаяр, Цэндийн Сандаг-Очир, Өлзийхүүгийн Шижир, Батын Батбаатар, Сархадын Зулпхар, Эрдэнэбилэгийн Одбаяр, Цэвэгдоржийн Туваан, Энхболдын Болормаа, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Гончигдоржийн Буянхишиг нарын гишүүд ирсэн байна.

Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал байгаа. “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

#### Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя.



Х.Булгантуяа Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга, Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, О.Цогтгэрэл Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүйн дэгийн байнгын хорооны дарга, А.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн, Б.Жаргалан гишүүн, Б.Найдалаа гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Түвшин гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, А.Ундраа гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, Д.Энхтүвшин гишүүн, С.Эрдэнэболд гишүүн, Б.Баасандорж Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга.

Мөн Р.Алтангэрэл Улсын Их Хурлын даргын зөвлөх. Ч.Ариунхур Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга, У.Хосжаргал Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх.

Эдгээр хүмүүс хүрэлцэн ирсэн байна.

Тогтоолын төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын дэд дарга, ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Х.Булгантуяа даргын микрофоныг нээж өгье.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Засаглал, бүлгийн зорилгыг Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин хүний эрхийг бүрэн хангасан шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэж тодорхойлсон байдаг.

Тус урт хугацааны хөгжлийн бодлогын “Ухаалаг засаглал” зорилтод:

▷ 2021-2030 онд Улсын Их Хурлын хууль тогтоох бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байна гэж;

▷ 2031-2040 онд хариуцлагатай, мэргэшсэн ёс зүйтэй гишүүдээр Улсын Их Хурлыг бүрдүүлнэ гэж;

▷ 2041-2050 онд ард түмний засаглах эрхийг хангасан хангасан итгэл хүлээсэн Улсын Их Хурал төлөвшинө гэж;

“Ухаалаг бүтэц” зорилтод:

▷ 2041-2050 онд төрийн бодлого, үйл ажиллагаа иргэн төвтэй болж, иргэн төвтэй захиргааны бүтэц төлөвшинө гэж хүрэх үр дүнг тусгасан.

Түүнчлэн “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм” зорилтот:

▷ 2030 он гэхэд хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдын тоог 126 болгон нэмэгдүүлж, Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх буюу хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу сонгуулийн холимог тогтолцоогоор явуулсныг гадаадад байгаа сонгогч, санал өгөгч иргэний сонгох эрх хангагдах, парламентын төлөөлөх чадвар сайжирч, эмэгтэйчүүд, залуучууд болон бусад нийгмийн бүлгийн оролцоо төлөөлөл болон сонгогчдын боловсрол нэмэгдэх зэрэг олон ач холбогдол бүхий өөрчлөлтүүдийг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 2024 онд шинэчлэн баталж, Улсын Их Хурлын стратеги, төлөвлөгөөтэй байх, түүнийг батлуулах, хэрэгжилтэд тавих нь Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эрх зүйн шинэ зохицуулалтыг бий болгосон.

Тиймээс Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 71 дүгээр захирамжаар “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг бат байгуулсан.

Энэ ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа, миний бие ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, О.Цогтгэрэл, Б.Баярбаатар, А.Ганбаатар, Б.Жаргалан, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, Б.Түвшин, Х.Тэмүүжин, А.Ундраа, Даваагийн Цогтбаатар, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласан хугацаанд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын стратеги төлөвлөгөөг анх 2002 он батлан хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан парламентын хариуцлага, эрх мэдлийн хяналт, тэнцлийг бэхжүүлэх парламентын хяналт шалгалтын үйл ажиллагааг төлөвшүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор хоёр дахь удаагаа 2019 онд батлан хэрэгжүүлж, 2024 онд үүсэх хугацаа нь дуусгавар болж байгаа.

Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Олон Улсын Парламентын Холбоо, гадаадын зарим улс улсын парламентын стратеги төлөвлөгөөг судлан өөрийн орны парламентын онцлогтой нийцүүлж, Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн судалгаа, дүн шинжилгээний тайлан, Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан болон Олон Улсын Парламентын Холбоо, Улсын Их Хурлын гишүүд, түүнчлэн 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, түүнд оролцогчдоос стратеги төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналыг судлан үзэж бид тусгасан.

Тогтоолын төслийг “D-Parliament” системд байршуулан санал авсан.

Нийт 2 удаагийн хэлэлцүүлэгт 800 орчим оролцогчид оролцсон.

Иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн оюутнууд гэх мэтчилэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 71 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын алсын хараа, түүнчлэн нийт иргэн, үндэсний язгуур эрх ашиг, сонирхлыг эрхэмлэсэн тогтвортой хөгжил, инновацад тулгуурласан нээлттэй, олон ургалч үзлийг хангасан парламент байх эрхэм зорилгыг тогтоолын төсөлдөө тодорхойллоо.

▷ Түүнчлэн Улсын Их Хурлын хууль тогтоомжийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатад хүн төвт үзэл санаанд суурилсан хүний эрхийг хангасан байх зарчим шаардлагыг тэргүүн эрэмбэд тавих.

▷ Хууль тогтоомж төрийн бодлогыг бодлогын баримт бичиг улс орны хөгжлийн зорилт, бодлогын уялдаа залгамж чанарыг хангасан байх.

▷ Хууль тогтоох үе шатад үр нөлөөний үл үнэлгээнд үндэслэж хууль тогтоомжийг боловсронгуй болгох.

▷ Хууль тогтоомжийг боловсруулах бүх үе шатад инновац, технологийн дэвшлийг дэмжих, цаашид парламентын үйл ажиллагаанд олон ургалч үзлийг хөхиүлэн дэмжих.

Гишүүд төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангах, нөхцөл боломжийг бүрдүүлэх зэрэг хүрээг хамруулан Монгол Улсын Их Хурлын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг батлах” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг хавсралтаар батлахаар тусгаж, тус стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгахаар тусгалаа.

Мөн эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчдаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлт гарган, нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах бүх үе шатад Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг шалгуур болгон хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалахад дүн шинжилгээ хийн үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллахыг Байнгын хороодод үүрэг болгохоор тусгалаа.

Түүнчлэн тус стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээний зардлыг жил бүр улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтэд нь жил тутамд мониторинг, 2 жил тутамд үр нөлөөний үнэлгээ хийж, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад даалгасан заалт тусгасан байгаа.

Тогтоолын хавсралтаар батлах Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний төсөлд Монгол Улсын Их Хурлын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг тодорхойлж, 5 зорилго, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх 16 зорилтыг хүрэх үр дүнгийн хамт Та бүхэнд танилцуулж байна.

1.Монгол Улсын Их Хурал “хүн төвт” хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлэх зорилгын хүрээнд хууль тогтоомжийг боловсруулах, батлах, биелэлтэд хяналт тавьж, тайлагнах хүртэлх бүх үе шатад “хүн төвт” үзэл санаанд суурилж хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалсан эсэхийг нягталдаг, дүн шинжилгээ хийдэг байх, Улсын Их Хурал Ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулан хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, олон талт түншлэлийг сайжруулах зорилтуудыг тусгасан.

Өнгөрсөн хугацаанд ялангуяа Улсын Их Хурлаас батлагдаж гарч байгаа хууль тогтоомжууд иргэний эрх, хүн төвд үзэл санааг тусгахаас илүүтэйгээр төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг илүү их данхар болгож байна. Төрд илүү их эрх мэдлийг өгч байна, хүний эрхийг зөрчсөн байд гэдэг юм уу, хүний эрхийг дээрдүүлсэн ийм зүйл, заалтууд бага байна гэсэн шүүмжлэлүүд иргэд, олон нийтээс хийсэн судалгаан дээрээс нэлээдгүй харагдсан.

2.Монгол Улсын Их Хурал үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжсэн цаг үеийн шаардлага, нийгмийн эрэлт хэрэгцээг тооцсон цогц шийдвэр гаргах зорилгын хүрээнд хууль тогтоомж,

Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа, залгамж чанарыг хангах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх зорилтуудад тусгасан байж байгаа.

Өнөөдрийн хэрэгжиж байгаа хууль тогтоомжууд шинэ цагийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

1990-ээд оны хууль тогтоомжууд өдий болтол хэрэгжиж байна гэсэн ийм шүүмжлэлүүд судалгаагаар гарсан байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд Улсын Их Хурал 126 гишүүнтэй олон төлөөллөөс бүрдсэн парламент ийм хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллах ёстой. Гарч байгаа хууль тогтоомжууд нь үүнийг хангах ёстой гэсэн зорилтыг дэвшүүлж байгаа юм.

3. Монгол Улсын Их Хурал шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшлийг дэмжих зорилгын хүрээнд хууль тогтоомжийг боловсруулахаас нь эхлэн батлах, биелэлтэд хяналт тавьж сурталчлах хүртэлх бүх үе шатад шинжлэх ухаанд суурилсан инновац, технологийн дэвшлийг дэмжиж, их өгөгдөлд суурилсан мэдээлэл дүн шинжилгээг шийдвэр гаргахад үр өгөөжтэй ашиглах талаарх зорилтуудыг бид тусгалаа.

Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “их өгөгдөл”-д суурилж шийдвэр гаргах нь хамгийн оновчтой талаар эрдэм шинжилгээний хурал, үүнийг ялангуяа Статистикийн ерөнхий газартаа гаргаж байсан.

Одоо улс Улсын Их Хуралд өргөн баригдаж байгаа зарим хуулиуд, жишээлбэл ялангуяа Засгийн газраас өргөн барьж байгаа зарим хуулиуд гэхэд нэг талын судалгаатай. Тэгвэл бид эдгээр хуулиудын нөгөө талын судалгааг нь хийж бас давхар хардаг.

Ялангуяа эрх нь зөрчигдөж байгаа талаас хийсэн судалгаа, эсвэл хэлэлцүүлгүүд харьцангуй бага орж ирдэг.

Тийм учраас үүнийг ялангуяа эрдэмтэн, судлаачидтай Улсын Их Хурал үргэлжлүүлэн судалж байж энэ хуулиуд нь, ялангуяа реформын шинж чанартай томоохон багц хуулиуд батлагдаж байх нь зүйтэй юм гэж үзэж шинжлэх ухааны байгууллагуудтай, эрдэмтэн судлаачидтай ажиллахаар тусгасан.

4. Олон ургалч үзэл бүхий дэвшилтэт шинэ үеийн парламентыг бэхжүүлэх зорилгын хүрээнд иргэд Улсын Их Хурлын гишүүдтэй олон талт сувгаар холбогдох нөхцөлийг сайжруулж гишүүд сонгогчдын өмнө ажлын гүйцэтгэл, ёс зүйтэй байдлаа хариуцан тайлагнадаг тогтолцоог төлөвшүүлэх, бүх нийтэд хүртээмжтэй, ёс зүйтэй, соён гэгээрүүлэгч дэвшилтэт шинэ үеийн парламентыг бэхжүүлэх зорилтуудыг тусгасан.

Өнгөрсөн хугацаанд D-Parliament 3-D буюу дижитал болсноороо олон

---

нийтэд Улсын Их Хурал илүү их нээлттэй, хууль тогтоомжид иргэд, олон нийтийн зүгээс саналаа өгөхөд илүү их нээлттэй болсонд сайшаалтай байгаа.

Гэхдээ үүнийг бид сайжруулах ажлууд нэлээдгүй байгаа. Жишээлбэл, D-Parliament дээр тавигдаж байгаа хуулиуд гэхэд өмнө нь энэ хуулиудтай нарийн танилцаж байсан. Хуульч хүн л хаана ямар өөрчлөлтүүд орж байгааг харна уу гэхээс биш төдийлөн иргэд, олон нийтийн зүгээс уншаад яг энд ийм өөрчлөлтүүд орж байгаа юм байна. Би үүн дээр нь бидний эрх ашгийг, иргэний эрх ашгийг ингэж зохицуулж сайжруулах гэж байгаа юм байна гэдэг ойлголтууд төдийлөн сайн авч чадахгүй байна.

Тэгэхээр олон нийттэй ажиллах сувгуудыг бид илүү сайн нээж өгөх ёстой. Гишүүдийн хувьд ажлын гүйцэтгэлээ илүү их тайлагнадаг, ойлголцдог, олон нийттэй холбогддог сувгуудыг нээх ёстой гэсэн энэ зорилтыг тавилаа.

5.Монгол Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлэх зорилгын хүрээнд Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулахад нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дэвшилтэт арга хэрэгсэл ашигладаг болохоос гадна Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлэх, парламентын хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг, өндөр бүтээмжтэй ажлын албыг бэхжүүлэх зорилтуудыг тусгасан байж байгаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх зардлыг холбогдох үйл ажиллагааны зардлын эх үүсвэрийн хүрээнд шийдвэрлэхээс гадна улсын төсөв олон улсын байгууллага, гадаад улсын төсөл, хөтөлбөрийн хүр хүрээнд шийдвэрлэх боломжтой байгаа.

Олон улсын төсөл, хөтөлбөрүүд ихэнхдээ гүйцэтгэх засаглал руу илүү их чиглэгдэж хэрэгждэг. Хууль тогтоогч Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газар луу чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүд харьцангуй цөөн байдаг нь өнгөрсөн хугацаанд анзаарагдсан.

Тэгэхдээ гүйцэтгэх засаглалын ажил сайжрахаас гадна хууль тогтоогч байгууллага зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд бидэнд бүхий л талаар дэмжин ажиллах, Олон Улсын Парламентын Холбоо, Азийн парламентын байгууллагуудын холбоо гэх мэтчилэн бид бүх талын энэ хамтын ажиллагааг өрнүүлж ажиллана.

Ингээд “Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрийн агуулга, зарчимтай бүрэн нийцсэн бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулаад шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** Х.Булгантуяа даргад баярлалаа.

---



Хэлэлцүүлж буй асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Хэн байна? Б.Батбаатар гишүүнээр тасаллаа.

С.Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурал 2024-2028 оныхоо үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө батлах гэж байна.

Тэгээд одоо батлах гэж байгаа стратеги төлөвлөгөө маань нөгөө Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын бичиг баримтуудын яг алинд нь хамрагдах юм бол?

Бид чинь урт хугацааны, дунд хугацааны, богино хугацааны гээд бодлогын бичиг баримтуудын төрлийг заачихсан. Урт хугацааных нь тийм байна, дунд хугацааных нь ийм байна, богино хугацааных нь ийм байна гээд заачихсан байж байгаа.

Тэгээд тэрэнд хамрагдах уу, хамрагдахгүй юу?

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028 оны хөтөлбөрүүдийг нь баталчихсан байгаа.

Одоо үндсэндээ Улсын Их Хурал маань 2024-2028 онд ийм бодлого, зорилго тавьж, ийм стратеги хэрэгжүүлж, ийм үр дүн гаргана гэдэг асуудал ярих гэж байна л даа.

Тэгээд үүнийг бид боловсруулахдаа урьд өмнөх стратеги төлөвлөгөөнүүдээ харьцуулж үнэлгээ хийж үзсэн үү?

2002 онд нэг стратеги төлөвлөгөө баталж байсан. Стратеги. Улсын Их Хурлын. 2019 онд бас баталж байсан.

Эдгээрийгээ харьцуулаад үүнээс авах давуу талууд юу байсан, сул талууд юу байсан, анхаарах зүйлүүд юу байсан гэдгийг бас нэг үнэлж дүгнэж үзсэн үү? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Тэгээд энэ удаагийн стратеги төлөвлөгөө батлаад 2028 онд Улсын Их Хурал маань ямар болсон байх юм бол, ямар үр дүнд хүрсэн байх юм бол. Үүнийг тооцож үзсэн болов уу?

2020-2024 оны парламент бол үндсэндээ онцлогтой. Ард түмний мэдэх эрхийг хангасан, хяналт шалгалтын чиглэлд илүү онцлогтой үйл ажиллагаа явуулсан. Нээлттэй сонсголууд, хяналтын сонсголууд хийсэн. Нүүрсний хулгай, хөгжлийн банк гээд л олон асуудлууд яригддаг.

---

2016-2020 оны парламентын үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд энэ талд нэг ахиц дэвшил гарсан.

2012-2016 онд сөрөг хүчин илүү хяналтаа сайн тавьж чаддаг, дуу хоолой нь илүү хүчтэй байсан.

2008-2012 онд хамтарсан Засгийн газартай Оюу Толгойн гэрээ байгуулж байсан гээд ганцхан том хөрөнгө оруулалтын гэрээ сүүлийн арван хэдэн жил, хориод жилийн хугацаанд өөр өөрийн онцлог байгаа юм.

Тэгээд энэ удаагийн парламентаас онцлог юу байх юм бол? Хамтарсан Засгийн газар байгуулагдсан байна. 126 гишүүнтэй болсон байна.

Энэ дотроо тэгээд “жагсаалтын гишүүн”, “тойргийн гишүүн” гээд өөр статустай юм шиг гишүүдтэй болсон гээд харахаар нэлээн олон онцлогууд байгаад байгаа юм л даа.

Үйл ажиллагаан дээр ч гэсэн онцлогууд, ялгаанууд нь харагдаж байгаа.

Тийм болохоор энэ парламентынхаа онцлогт таарсан, тэгээд энэ цаг үеийн нөхцөл байдалдаа таарсан тодорхой бодлого, зорилго, стратеги байх юм уу, эсвэл уламжлалт байдлаар бичсэн байдалтай ийм байх юм уу? Үүнийг тодорхой хариулж өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Х.Булгантуяа гишүүн хариулъя дарга хариулъя.

**Х.Булгантуяа:** Эхлээд дэд ажлын хэсгээс тэр өмнөх стратеги дээр хийсэн судалгаагаа PowerPoint презентаци дээр байсан. Тэрийг товч хариулаад. Зарим асуултуудад хариулчих.

**Ж.Бат-Эрдэнэ:** 5 номерын микрофон.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга.

**Б.Баасандорж:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя.

Өмнө нь манай 8 удаагийн Улсын Их Хурал 2002 онд нэг стратеги баталж байсан.

2019 онд Улсын Их Хурлынхаа тухайн бүрэн эрхийн хугацааны стратегиа баталж байсан.

---



2019 оны стратеги дээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байдаг. Яг өмнөх парламентын бүрэн эрхийн хугацаанд.

Тэр үнэлгээтэй Х.Булгантуяа даргын ахалсан ажлын хэсэг танилцсан байгаа.

Тэгээд зүгээр харьцуулах юм бол ер нь 2000, 2019 оны Их Хурлын стратеги маань 65-аас 70 хувь нь дотогшоогоо чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдтэйгээ одоо стратеги төлөвлөгөө, арга хэмжээгээ цуг баталсан байсан.

Үлдсэн 30 орчим хувь нь гадагшаагаа чиглэсэн үйл ажиллагаа байсан.

Тэгэхээр өөрөөр хэлбэл бид 2002 оны стратеги, 2019 оны Их Хурлын стратегиудтайгаа нэг бүрчлэн танилцаж түүн дээр байсан сайн талууд, мөн сул талууд, цааш нь үргэлжлүүлэх арга хэмжээнүүд төлөвлөгөөн дээр бид нэг бүрчлэн ажилласан байгаа.

Мөн С.Бямбацогт гишүүн сая Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн хуультай холбогдуулж асуулаа.

Тэгэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль дээр дунд хугацааны стратеги гэж юу юм бэ? Дунд хугацааны стратегид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 5 жилийн улсын хөгжлийн төлөвлөгөө, 10 жилийн зорилтот хөтөлбөр дунд хугацааны стратегидаа ордог.

Манай Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги маань энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар зохицуулагдахгүй.

Өөрөөр хэлбэл дунд хугацааны стратегид шууд хамаарахгүй. Их Хурлын тухай хуулийн 4.8-д заасны дагуу Улсын Их Хурал өөрийн. Өөрийн гэж байгаа шүү. Өөрийн стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хуулийн 4.8-д заасны дагуу Х.Булгантуяа даргаар ахлуулсан ажлын хэсэг Их Хурлын хуульд заасны дагуу одоо энэ 4 жилийн бүрэн эрхийн хугацааны стратегиа Та бүхэнд танилцуулж байна гэж ойлгогдож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Х.Булгантуяа дарга.

**Х.Булгантуяа:** Энэ удаагийн парламентын зарим нэг зорилго, зорилтуудыг Улсын Их Хурлын дарга анх чуулган эхэлж байхад хэлж байсан.

Бид илүү хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн парламент байх ёстой. Нэгдүгээрт.

Ялангуяа иргэдийн зүгээс төр улам их данхайсан, төрийн бүтэц, эрх мэдлийг

улам их нэмэгдүүлсэн ийм хууль тогтоомжууд гараад байна гэдэг ийм шүүмжлэлүүд их байна.

Тийм учраас бид энэ удаагийн парламентыг хууль тогтоомжууд нь иргэний эрх, хүний эрх, эрх чөлөөг илүү их дээдэлсэн, илүү их хангасан ийм хууль тогтоомжууд гарах дээр онцгой анхаарна.

Хоёрдугаарт, бид хууль тогтоомжийн хоцрогдлуудыг арилгахад илүү их чиглэгдэнэ.

1990-ээд оны зарим. Одоо яг үнэнийг хэлэхэд бизнесийн эрх зүйг зохицуулж байгаа хууль тогтоомжууд хүртэл төдийгөөс өдий болтол зарим нэг нэмэлт, өөрчлөлт оруулаад л төдийгөөс өдий болтол явж байгаа.

Үүнийг ялангуяа эдийн засгийн өсөлтийг, дээрээс нь би шинэ цагийн хэрэгцээ шаардлагыг огт хангахгүй байна гэдэг шүүмжлэлүүд судалгаагаар гарсан. Энэ рүү илүү их чиглэгдсэн байна.

Ийм ч учраас манай аль аль намуудаас салбар салбарын төлөөллүүд энэ удаагийн парламентад орж ирсэн.

Гурав дахь нь, журмыг журамлая гэж бид яриад байгаа юм. Хуулиасаа олон журамтай болчихсон. Дээрээс нь нэмээд орон нутаг, сумын иргэдийн хурал нь хүртэл хуралдаж байгаад л журамтай болчихсон.

Хамгийн олон журам иргэдийн Хурлаас гарсан байна лээ.

Тэгэхээр үүнийг хуульд нь шингээж өгдөг. Бид аль болохоор журмын тоог цөөлсөн, хууль нь илүү их сайн бичигдсэн. Дарга нар өөрсдөө журамлаж, эрх зүйн актууд үйлдээд байдаг. Үүнийгээ бид багасгахад чиглэсэн. Энэ удаагийн парламент ийшээ илүү их чиглэгдсэн байх зорилго, зорилтыг тавьж байгаа.

Тийм ч учраас бид олон ургалч үзлийг дэмжинэ, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ, үйл ажиллагаандаа дэмжинэ, гэх мэтчилэн эдгээр зорилтуудыг өөрийнх нь зорилтод оруулж өгсөн байгаа.

Энэ удаагийн Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд бид хяналт шалгалтын.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Тодруулах юм уу? С.Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** 2019 оны стратегийг Б.Баасандорж дарга жаахан дутуу л ярьчих шиг боллоо.

Тэр дээр яг харьцуулаад дүгнээд давуу тал нь юу байсан, сул тал нь юу байсан, цаашид анхаарах юм юу байсан, залгамжлаад аваад явж байгаа юм нь юу

байсан. Үүнийг нэг тодорхой хариулж өгмөөр байх юм.

2019 оны батлагдсан стратеги, үнэт зүйлс дотор тэгш байдлыг хангах, иргэдийн оролцоог хангах, чадавхтай байх, хамтын шийдвэрийг хүндэтгэх гэх мэтийн үнэт зүйлс байсан. Тэр хасагдсан байх юм.

Уг нь цаашдаа эд нар хэрэгтэй л байсан байх. Байх ёстой л байх юм. Яагаад хасчихсан юм бол?

Ер нь цаашдаа бид энэ үнэт зүйлс, тэгээд дээрээс нь алсын хараа, эрхэм зорилго гээд энэ юмнуудаа Их Хурал болгон өөр өөрсдөө тухай бүртээ өөрчлөөд явах юм уу? Уг нь Үндсэн хуулиараа хууль тогтоох, эрх барих дээд байгууллага гэгчихсэн. Улсын Их Хурлын тухай өөрөө хуультай байж байхад нэг өөрчлөхгүй яваад байж болохгүй юу.

Тэгээд л Их Хурал болгон өөрсдөө стратеги баталдаг. Ингэхдээ яах вэ, стратегийн зорилтуудаа өөрчилж болно. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулаад.

Эрхэм зорилгоо өөрчлөөд байх нь зөв үү, буруу юу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** 6 номер. У.Хосжаргал. Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх.

**С.Бямбацогт:** Урдахаа хэр сайн дүгнэсэн юм бол оо?

Тэгээд би түрүүн асуугаад байна шүү дээ тийм ээ.

Өнөөдрийн нөхцөл байдал чинь бас өөр болчихоод. 126 гишүүнтэй болсон. 76 гишүүнтэй байх үед нөхцөл байдал нэг өөр байсан.

Хууль тогтоол хэлэлцэх нэг өөр байсан. Дэгийн тухай хууль өөрчлөгдөөд бас нэг өөрчлөгдчихсэн.

Дээрээс нь “жагсаалтын гишүүн”, “тойргийн гишүүн” гээд гишүүдтэй болчихсон.

Ингээд нөхцөл байдал маань өөрчлөгдсөн байгаад байдаг. Энэ ч сая төсвийн хэлэлцүүлгүүдээс харагдаж байна шүү дээ.

Тийм болохоор энэ нөхцөл байдал дунд ард түмний мандатыг өвөрлөж орж ирчхээд яаж итгэлийг даах вэ? Төрдөө итгэж байгаа төрийн эрх барих дээд байгууллага маань эхнээсээ л зөв явахгүй бол мордохын хазгай болчих вий.

Нөгөө “дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй” болох вий.

---

Тэгэхээр бидний стратеги маань зөв гарч өгөх юм бол тэрийг дагаад бид зөв явна.

Тэгэхгүй зүгээр нэг тийм хэлбэрийн төдий стратеги.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 6 номерын микрофон.

**У.Хосжаргал:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Намайг У.Хосжаргал гэдэг.

Стратеги боловсруулах ажлын хэсэгт хөндлөнгөөс судлаач гэж статустай оролцож байгаа.

Бид стратегийг боловсруулахдаа нийт 30 гаруй орны гадаадын стратеги, яг Улсын Их Хурлын стратеги ямар байдаг талаар судалсан.

Мөн нийт 21 аймаг, 9 дүүргийг хамарсан 2500 орчим иргэдээс судалгаа авсан байгаа.

Яг сая гишүүний хэлсэнчлэн бид өмнөх 76 гишүүнтэй байхад ажиллаж байсан парламентын үнэлгээ, 126 буюу шинэ парламентын түвшинд ямар хүлээлттэй байгаа вэ гэдэг судалгааг түлхүү авсан.

Энэ судалгааны үндсэн дээр нийт 56 буюу түүнээс дээш хувийн иргэдийн хүлээлт энэ иргэд рүү чиглэсэн хууль тогтоомжтой байх, иргэдийн нийгэмд тулгамдаж байгаа асуудлуудыг цогцоор шийддэг байх гэдэг асуудлуудыг гаргаж ирсэн.

Энд нийслэлийн иргэдийн 65 хувь нь “утаа”, түгжрэл” иргэд рүүгээ чиглэсэн парламент байгаасай гэдэг дуу хоолойг илэрхийлсэн нь өндөр байсан.

Олон улсын парламентын байгууллагатай хамтраад 30 гаруй орны парламентын стратегийг судалж үзэхэд үндсэн тулгын гурван чулуун дээр ер нь бүгд түшиглэсэн байсан.

Нэгдүгээрт, иргэдэд их ойлгомжтой “People center” буюу “Хүн төвтэй парламент” гэсэн бодлогыг дэлхий даяар, ялангуяа пандемикийн дараа буюу ковидын дараа маш өндөр ач холбогдол өгч байгаа юм билээ.

Хоёрдугаарт, үндэсний язгуур эрх ашгийг цогцоор нь шингээчихсэн байх ёстой. Парламент хууль санаачлах, боловсруулах дээд байгууллагын хувьд үүнийг заавал авч үзсэн байх ёстой.

Гуравдугаарт, хамгийн чухал зүйл бол дижитал эринд бүх салбар дижитал шилжилттэй холбогдож байна. Инновац, шинжлэх ухаан дээр суурилахгүйгээр “хууль тогтоох”, “хэрэгжүүлэх”, “хянах процесс” явах боломжгүй юм байна гэсэн ийм гурван агуулгын хүрээнд бол бид бас нэлээн.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Х.Булгантуяа дарга нэмж хариулъя.

**Х.Булгантуяа:** Өнгөрсөн удаагийн стратеги түрүүн Б.Баасандорж дарга хэлж байсан. Бараг 60, 70 хувь нь илүү их дотогшоогоо чиглэсэн. Үлдсэн нь илүү их гадагшаагаа чиглэсэн байсан.

Энэ удаа бид иргэдийн санаа бодлын судалгаа хийж үзэхэд олон нийт рүү чиглэх дээр тааруухан байна. Хууль тогтоомж гарч байгаа гэсэн мөртлөө бид энэ тухай мэдлэг мэдээлэл дутуу байна. Оролцоог хангаж чадахгүй байна гэх мэтчилэн ийм байсан учраас бид эсрэгээр нь гадагш нь чиглэснийг илүү их нэгдүгээрт нэмэгдүүлж өгсөн.

Мөн IPU-ийн Олон Улсын Парламентын Холбооны үндсэн стратегийг бид харгалзаж үзэж, энэ үнэт зүйл гэх мэтчилэн гаргасан. Манай Улсын Их Хурлын гишүүдээс ч гэсэн гарсан.

Жишээлбэл, “Хүртээмжтэй байдал” гэдэг оролцоог ороогүй байна гэдгийг манай О.Саранчулуун гишүүн гарч байсан.

Энэ удаагийн парламент хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл орсон парламент байхад манай парламентын үйл ажиллагаа явуулж байгаа танхим, заалаас авхуулаад заримдаа хүртээмжтэй биш байна.

Дээрээс нь нэмээд гаргаж байгаа бодлого шийдвэрүүдээ хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэж чадахгүй байна.

Үндсэн хуульд заасан зарчим заалтыг Улсын Их Хурал хэрэгжүүлнэ.

Тэгэхдээ Үндсэн хуульд заасан зарчмыг бүхэлд нь тусгах шаардлагагүй.

Угаасаа Үндсэн хуулийг баримтална гэж үүн дээр орж байгаа учраас гэж бас үзсэн байж байгаа.

Дижитал шилжилт, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх талаар зарим асуудлаар өмнөх стратеги дээр их сайн туссан байсан.

Үүнийг энэ парламент дээр бас үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан байгаа.

Өмнөх парламентын ялангуяа хамгийн сайн хэрэгжсэн, олон нийтэд их сайн хүрсэн нь дижитал шилжилт, хяналт шалгалтын үр нөлөө гэж манай судалгаагаар гарсан байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Зулпхар гишүүн асуултаа асууя.

---

**С.Зулпхар:** Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурал хууль тогтоох байгууллагын хувьд ирэх 4 жилд ямар стратеги баримтлах юм бэ гэдэг ийм бодлогын баримтыг бид боловсруулчихсан байгаатай танилцаж байна.

Үүнийг хэлэлцэж батлах нь өөрөө их чухал ач холбогдолтой гэдгийг ойлгож байна.

Мэдээж хэрэг энэ дээр их олон талын оролцоо байсныг ч гэсэн бид мэдээллийн дагуу авсан.

Эрдэмтэд оролцсон байна. Судлаачид оролцсон байна. Иргэд оролцсон байна.

Цаашлаад яах вэ бид ч гэсэн ажил хэргийн шугамаар мэдээлэл авсан. Яах вэ би нэг ийм гурван асуулт асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, яг бидэнд энэ танилцуулсан хэлбэрээрээ стратегийн баримт бичгийг бид батлах юм гэдгийг Та бүхэн ажлын хэсэг болон өмнөх ер нь баримт бичгүүдээ харж байгаад ч юм уу, үүнийг эцэслэсэн үү, тохирсон уу гэж байгаа юм.

Яг ийм форматтай байх уу?

Хоёр дахь зүйл бол нэгэнтээ стратегийн төлөвлөлтийн баримт бичиг юм бол үйл ажиллагаа болон шалгуур үзүүлэлтээ энэ дээр тусгах юм уу?

Хэрвээ тусгахгүй бол ямар хэлбэрээр, ямар баримт бичигтэйгээр үүнийг оруулж ирж танилцуулах вэ гэдэг бас нэг ийм асуулт байна гэж байгаа юм.

Тэгээд яг үүнтэй уялдсан байдлаар дараагийн асуулт гарч ирээд байна л даа.

Одоо ингээд бид санал гаргах гээд байна л даа. Зорилго, зорилттой холбогдуулаад. Бусад жишээ нь хэл найруулгатай холбогдуулаад.

Тэгэхээр энэ саналыг гаргахаар зэрэг ажил хэргийн шугамаар аваад эндээ тусгавал тусгаад, тусгахгүй бол тусгахгүйгээ хэлэх юм уу, эсвэл бид ямар нэгэн байдлаар зарчмын зөрүүтэй санал хэлбэрээр үүнийг гаргах уу? Яаж үүнийг бид тусгуулах вэ гэдэг нэг ийм л асуулт байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Х.Булгантуяа дарга.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлаар “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” гээд тогтоолын төсөл.

---

Тогтоолын төслийн хавсралтаар “стратеги төлөвлөгөө”, “алсын хараа”, “зорилго”, “үнэт зүйл”, ингээд “зорилго, зорилт” гэх мэтчилэн батлагдахаар тусгасан.

Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд Та бүгдийн саналыг бид энэ дээр нарийвчлан тусгахад бэлэн байна.

Та бүхэн үүн дээр саналаа өгөөрэй. С.Зулпхар гишүүнийг ажлын хэсэг дээр нь яг оруулах ёстой байсан байна.

Та чинь энэ мэргэжлийн нарийн эрдэмтэн судлаач хүн учраас.

Дээрээс нь шалгуур үзүүлэлтүүдийг бид сая стратеги төлөвлөгөө дээр нэг нэгэнгүй тусгаж орж ирэх гэхээр их том болох гээд байсан юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь бид арга хэмжээний энэ тогтоолын төслийн 2-т Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Улсын Их Хурлын байнгын болон дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай гээд Улсын Их Хурлын тухай хуультай нийцүүлээд бид ингэж оруулж өгсөн.

Тэгэхээр таны хэлээд байгаа шалгуур үзүүлэлтүүд, жил жилийн төлөвлөгөөнүүд жил жилээрээ Төрийн байгуулалтын байнгын хороогоор тусгайлан орж батлагдана гэсэн үг.

Жишээлбэл, ирэх жилд гээд тэгж байхад бид энэ хэдэн жилийн дотор нөгөө нийт журмуудаа үзэж байгаад яг зайлшгүй журамтай байх хэрэгцээ шаардлага байгаа. Тийм ээ. Цахимтай холбоотойгоор байдаг юм уу.

Тэгвэл журмын тоог ирэх 2025 онд ингэж ингэж бууруулна, хүний эрхийн ийм ийм индексүүдийг ингэж ингэж сайжруулна гэж оруулж өгөх нь зүйтэй байх.

Заримыг нь тооцоолоход их хэцүү юм байна лээ. Шалгуур үзүүлэлтүүд нь.

Жишээлбэл, “ил тод, нээлттэй байна” гэдэг юм уу, “олон ургалч үзлийг эрхэмлэнэ” гэхээр яг “олон ургалч үзлийг эрхэмлэнэ” гэдгийг Улсын Их Хурлынхаа үйл ажиллагаанд яаж тэрүүнийг тусгах вэ, яаж тэрийг шалгуур үзүүлэлт болгох вэ гэдэг бол бас их амаргүй.

Тэгэхдээ энэ бол олон улсуудын парламентад бас байдаг.

Нөгөө талдаа бид үүнийг юу гэж хараад байгаа вэ гэхээр өнгөрсөн хэд хэдэн удаагийн парламент дээр шүүмжлэлтэй хандаж байсан зүйлүүд нь нэгдүгээрт Улсын Их Хурал тодорхой хэмжээгээр Улсын Их Хурлын үүд хаалгаар орж ирж

байгаа хуулиуд дээр, өргөн барьж байгаа бичиг цаасан дээр гишүүд ч өргөн барьсан бай, Засгийн газар ч өргөн барьсан бай тодорхой шаардлагуудыг тавихгүй бол болохгүй байгаад байна.

Бүр ийм шүүмжлэл гарч байсан шүү дээ. Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал нэг хуулийн хэлтэс шиг ажиллаж байна. Хуулийн газар, хэлтэс шиг.

Үг, үсгийн алдаа. Ингээд таслалыг нь хүртэл найруулаад сууж байдаг.

100 гаруй зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт хийгээд хагас дутуу боловсруулсан хуулиуд дээр ажиллаж байна гэдэг нэгдүгээрт ийм шүүмжлэл байсан.

Хоёрдугаарт, нэг гишүүнийг хуулийг арай гэж ахлаад. Түрүүний нэг тод жишээ бол одоо манай С.Бямбацогт гишүүн ахлаад нарын гишүүд өргөн барьж байсан.

Тэгээд өмнөх тэрүүний 2016-2020 оны парламент. Зөвшөөрлийн тухай хууль Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг ахлаад батлуулчихсаныхаа дараагаар тэр хуулийн хэрэгжилт дээр хяналт тавих нь бараг Х.Ганхуяг гишүүний ажил шиг болчихоод байгаа юм.

“Зөвшөөрөл” гэсэн үг, үсэг ороод л ирэнгүүт Х.Ганхуяг л түүнд хяналт тавиад, ямар зөвшөөрөл вэ, хууль дээр тэр нь суусан уу, нийцсэн үү гэх мэтчилэн.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Зулпхар гишүүний 2 дугаар асуултын хувьд бол одоо энэ дээр бид нээлттэй шүү дээ. Засахын хувьд. Засаад, саналаа гаргаад, тэгээд хэдүүлээ хэлэлцээд тодорхой хэмжээнд саналаа хураагаад явчих бололцоотой.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгээд дараа нь чуулган руу оруулах юм шүү. Тийм саналаа өгөөд, зарчмын зөрүүтэй санал гаргаж ирээд тэгээд явчих нээлттэй шүү тийм.

Ц.Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа.

Бид ч хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл батлаад хэрэгждэг бол сайхан л байна.

Харамсалтай нь хэрэгжилт, үр дүн тооцдоггүй, хянадаггүй, эргэж хардаггүй, тайлагнадаггүй ийм хөтөлбөр төлөвлөгөөнүүд олон байгаа шүү дээ.

Тэгээд би Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль зүйн хэлтэс яг юу хийдэг юм?

Миний анзаараад, буруу бодоогүй бол одоогийн манай Улсын Их Хурлын дарга бол Монгол Улсад хэрэгжиж байгаа энэ 700, 800 хууль дотор бараг л 800



орчим хүний эрхийн зөрчилтэй хуулийн зүйл, заалтууд байна гэж хоёр, гурван жилийн өмнө ярьж байсныг би санаж байна.

Одоо тэгвэл энэ хүний эрхийн зөрчилтэй зүйл, заалтуудыг засах сайжруулах ийм ажил хийгдэж байна уу, үгүй юу?

Үнэхээр тэгээд олоод тогтоочихсон юм бол тэгээд мэдэж байгаа юм бол яагаад үүнийг засахгүй байгаа юм?

Энэ олон хүний эрхийн зөрчилтэй хуулийн зүйл, заалтууд орж ирж хууль болж батлагдаж байхад Улсын Их Хурлын хуулийн хэлтэс нь юу хийж байдаг юм, юу харж байдаг юм.

Бүхэл бүтэн энэ стратеги төлөвлөгөөнийхөө үнэт зарчим, стратеги зорилтдоо болохоор, эрхэм зорилгодоо болохоор хүний эрхийг баталгаажуулна гэсэн ийм зүйл, заалт үг, өгүүлбэр оруулчихсан л юм шүү дээ.

Тэгсэн хэрнээ тэгээд хаана нь тэрийг нь хянаад сууж байдаг юм. Батлагдсаных нь дараа л бөөн асуудал болоод л. Ийм ч хүний эрхийн зөрчилтэй асуудал болчихлоо, болчихсон байна гээд яриад сууж байх юм.

Энэ асуудлыг гарахаас нь өмнө, хууль төрөхөөс нь өмнө, батлагдахаас нь өмнө хүний эрхийн зөрчил хаана нь байна, хэрвээ энэ хууль батлагдвал ийм хүний эрхийн зөрчил үүсэхээр байна гэдгийг гишүүдэд яагаад урьдчилан хэлэлцүүлгийн дундуур ийм хууль батлуулахгүйн төлөө ажилладаггүй юм.

Энэ дээр юу хийж байдаг юм Тамгын газар, хуулийн хэлтэс гэдгийг нэгд асууя.

Хоёрт, энэ харлаа. “Алсын хараа”, “эрхэм зорилго”, “үнэт зүйлс” гээд.

Энэ агуулгууд дотор ерөөсөө шударга гэдэг ойлголт, агуулга ерөөсөө байхгүй юм. Шударга.

Өнөөдөр Монголын нийгэмд ус агаар мэт хэрэгтэй байгаа ойлголт агуулга бол шударга байдал биз дээ.

Би ингээд харахаар ерөөсөө хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулна, олон ургалч үзэл, төлөвшлийг хангана, ил тод, нэттэй байдлыг хангана.

“Шударга” гэдэг ойлголт агуулга ерөөсөө байхгүй байна шүү. Энэ Улсын Их Хурлын энэ стратеги төлөвлөгөө чинь. Хэрвээ үүгээрээ батлагдвал.

Тэгээд бид энэ хууль тогтоохоосоо авхуулаад энэ хуулиудыг батлахдаа шударга байдлын асуудлыг тусгаж явахгүй юм уу? Хэрвээ ингэвэл цаашдаа нийгэмд шударга байдлын асуудал ярих утгагүй болно биз дээ.

---

Улсын Их Хурал нь өөрөө стратеги төлөвлөгөөндөө энэ байдлыг, агуулгыг ойлголтыг оруулахгүй юм бол. Энэ дээр цааш цаашдаа дараагийн хэлэлцүүлгүүд дээр бас энэ дээр анхаараад оруулах бололцоо боломж нь.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Баасандорж дарга. Ерөнхий нарийн бичгийн дарга. 5 дугаар микрофон.

**Б.Баасандорж:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Ер нь өмнөх батлагдсан хуулиудтай холбоотой өмнө нь ер нь яг юу хийгдэж байсан юм бэ гэдэг зүйлийг ярьж байна. Нэг дэх асуудал.

Тэгэхээр 2024 оны 7 сарын 02-ноос 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнд бий болсон Улсын Их Хурал маань бүрэн эрхээ хэрэгжиж эхэлсэн.

Яг үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэмд заасны дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргатай зөвшилцсөний үндсэн дээр Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон байгаа.

Зарчмын хувьд гишүүн ээ, тантай санал нэг байна. Яг энэ хүний эрхийн асуудал бол шат бүр дээр яригдаж байх ёстой.

Яг таны хэлж байгаа саналыг ер нь үндэслээд энэ 5 зорилго, 16 зорилт бүхий Улсын Их Хурлын стратеги дээр яг энэ агуулга шингэсэн байгаа.

Тэгэхээр ерөөсөө, өөрөөр хэлбэл яг энэ стратегийн хүрээнд 11 Байнгын хороо, дэд хороодууд, хяналт шалгалтын түр хороодууд ерөөсөө яг энэ хүний эрхийн чиглэлээр л онцгой анхаарч ажиллах үзэл баримтлал үзэл санаа энэ 5 зорилгодоо шингэж өгсөн байгаа шүү, гишүүн ээ.

Хоёрт нь, Улсын Их Хурлын дарга хүний эрхтэй холбоотой, хүний эрхийг хангахтай холбоотой чиглэсэн хэд хэдэн ажлууд хийгдэж байгаа.

Өөрөөр хэлбэл сая гарсан 54 ажлын хэсгийн 14 нь яг шууд утгаараа хүний эрхийг хангахтай холбоотой, хүний эрхийг хамгаалахтай холбоотой ажлын хэсэг байгаа.

Яг энэ ажлын хэсэг мөн өнөөдөр ингээд ажиллаад хэрэгжилт нь хангагдаад эхнээсээ ажлууд нь явж байгаа гэдгийг тандаа онцолж хэлье.

Хоёр дахь асуудал “шударга” гэдэгтэй холбоотой та санал хэлж байна.

Тэгэхээр та энэ 5 зорилгын яг аль санал дээр нь шардга гэдгээ яах юм бол. Дэгийн тухай хуульд заасныхаа дагуу та зарчмын зөрүүтэй саналаа гаргаад

“шударга” гэдэг нэр томъёог оруулахтай холбоотой асуудал нээлттэй байх гэж бодож байна. Дэгийн тухай хуулиараа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ц.Сандаг-Очир гишүүн дахин тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Ойлголоо.

Энэ хүрэх үр дүн чинь тодорхойгүй байна. Бас. Тайлагна л гэж байна.

Тэгээд яг ингээд хэн хариуцлага хүлээх юм? Хэн хариуцах юм? Хууль зүйн байнгын хороо юуг нь хариуцах юм, Төрийн байгуулалтын байнгын хороо юу хариуцах юм, Улсын Их Хурал юу хариуцах юм.

Эзэн биегүй болохоор дундаа яваад байгаа байхгүй юу. Найзан дундаа.

Тэгэхээр эндээс чинь ерөөсөө хариуцлагын асуудал нэг хариуцлагын өгүүлбэр байх шиг байна. Тэгээд л өөр юм байхгүй.

Тэгэхээр ерөөсөө ингээд найзан дундаа яваад байгаа учраас үүнийг чинь хэн ч үнэлж тооцохгүй, хүрэх үр дүн нь тодорхойгүй, 4 жилийн дараа бахь байдгаараа ийм л байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас хариуцлагатай байлгах үүднээс эзэнжүүл ээ. Хэн хариуцах юм. Улсын Их Хурлын Тамгын газар нь хариуцах юм уу, Хууль зүйн хэлтэс нь хариуцах юм уу, Улсын Их Хурлын дарга нь хариуцах юм уу, Байнгын хороодод нь хариуцах юм уу гэдгийг эзэнжүүл.

Ингэж байж энэ чинь хүрэх үр дүн юм нь бас нэг тодорхой болох юм болов уу л гэсэн нэг ийм саналтай байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэмж хариулъя. Х.Булгантуяа дарга.

**Х.Булгантуяа:** Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа үнэн.

Одоо тийм болохоор бид Төрийн байгуулалтын байнгын хороогоор тогтоолын төслийн 2-ын дагуу жил болгон арга хэмжээний төлөвлөгөө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороон дээр орж ирж батлуулахаар байж байгаа.

Энэ дээр бүх Байнгын хороо нь, тэр битгий хэл дэд хороо, тэр тусмаа Хүний эрхийн дэд хороо гэх мэтчилэн дэд хороод үүрэг хариуцлагууд хүлээнэ.

Хүний эрхийн асуудлууд байдаг юм уу, эдгээр асуудлууд аль нэг Байнгын хороон дээр харьяалагдахад хамаарахад бас хэцүү. Бүхий л Байнгын хороод энэ олон хууль тогтоомжуудыг батлахад эдгээр зарчмуудыг, эдгээр үнэт зүйлийг эрхэмлэнэ л гэж орж байна гэсэн үг.

---

Хэрвээ ингэж чадахгүй бол жишээлбэл түрүүний хэлсэнчлэн журмыг ирэх жил тэдээр цөлнө өө, тэр Байнгын хороо тэд гээд.

Бид хаврын чуулганаар хэлэлцэх асуудлаа баталдаг шүү дээ.

Тэгэхээр яг үүнтэй уялдуулаад бид жишээлбэл оруулж өгнө гэсэн үг.

Ингээд энэ төлөвлөгөөнийхөө дагуу ажлуудаа Байнгын хороодууд нь хийж чадахгүй хийж чадахгүй бол одоо тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороо төлөвлөгөөгөө батлахдаа үүнийгээ дагаж мэдээж тогтоол батлагдах байх.

Тэгээд энэ дээр хариуцлагын асуудал, хэрхэн яаж ажлыг нь дүгнэх вэ гэдэг асуудлууд давхар дурдагдах байх гэж бодож байна.

Өмнө нь бид стратеги төлөвлөгөөгөө батлахдаа гол нь таны хэлж байгаагаар энэ асуудлууд тусгагдаагүй учраас нэг хэцүү нь үүнтэй холбоотой хариуцлагын асуудлууд, үнэлэлт дүгнэлтийн асуудлууд жоохон хоцрогдчихсон юм билээ.

Гэхдээ тэр 800 гаруй хүний эрхийн зөрчилтэй зүйл заалтуудыг өнгөрсөн 4 жилд тал орчим хувиар бууруулсан. Энэ бол сайн үзүүлэлттэй.

Тэгэхээр үлдсэнийг нь бид сайжруулах ажил энэ парламентад үлдэж байна гэсэн үг.

Дээрээс нь нэмээд нэлээдгүй шинэ хуулийн зохицуулалтууд, шинэ хуулиуд орж ирж байгаа. Шинэ сайд нараас, шинэ Засгийн газраас.

Тэгээд энэ дээрээ хүний эрхийн асуудлуудыг ер нь сайн тусгаж өгөх ёстой.

Ингээд харахад ер нь ихэнх хуулиуд, ялангуяа том реформын шинж чанартай хуулиуд Засгийн газраас орж ирдэг. Засгийн газраас орж ирдэг.

Энд бас хэд хэдэн Засгийн газрын сайд нар сууж байна.

Ингээд яг л нэг талыг баримталсан судалгаагаа хийгээд л хуулиа батлуулах гээд л яг нөгөө хуулийнхаа үзэл баримтлалтай нийцсэн.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Сая Х.Булгантуяа дарга, ажлын хэсгийн дарга бас нэмж тайлбарлалаа.

Урьд өмнө бид стратеги төлөвлөгөө батлахдаа хяналт дээр ерөөсөө хяналт тавиагүй байсан юм билээ.

Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дээр орж ирж байгаа Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Улсын Их Хурлын Байнгын хороод болон дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Ж.Бат-Эрдэнэд даалгасугай гээд ороод ирж байгаа юм.

Дээр нь 4 дээр Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандоржид даалгасугай гээд ингээд ороод ирж байгаа юм шүү.

Тийм болохоор бас тодорхой хэмжээнд энэ удаагийнх өөрчлөлт ороод эзэн биетэй болоод ороод ирж байгаа юм.

Ц.Сандаг-Очир гишүүн тодруулья.

**Ц.Сандаг-Очир:** Энэ стратегийн зорилтуудаа бас энэ хууль хоорондын зөрчлүүдийг бас та нар маань харах ёстой юм билээ.

Хууль хоорондын зөрчлүүдээс болоод өнөөдөр үр дагавар нь гараад явж байгаа сонгуультай холбоотой гэхэд наад зах нь Сонгуулийн хуулиараа давхар нэр дэвшихийг хориглочихсон. Тэгээд нэгжийн хуулиараа давхар нэр дэвшихийг нь зөвшөөрчихсэн. Тэгээд аль хуулийг нь барих юм.

Энэ хуулиас чинь болоод өнөөдөр орон нутаг. Сая 10 сард болсон орон нутаг, аймаг, сум, дүүргүүд дээр энэ хуулийн чинь зөрчлөөс болоод өнөөдөр засаглалаа байгуулж чадахгүй явж байгаа аймаг, орон нутгууд зөндөө байж байна шүү дээ.

Тэгээд ийм зөрчилтэй хуулиудыг баталчихсан. Энэнийх нь хаагуур нөгөө Их Хурлын Тамгын газар нь, Хууль зүйн хэлтэс нь хяналтаа тавиад хууль батлагдахад үнэлгээ дүгнэлт өгөөгүй, харж үзээгүй ийм хууль батлуулснаас болоод ингээд үр дагавар нь өнөөдөр ингээд бүхэл бүтэн орон нутаг засаг захиргааны нэгж, засаглал удирдлагаа томилж чадахгүй гацаанд орчихсон байдалтай байж байна шүү дээ.

Үүнийг та нар юу гэж үзэж байгаа юм. Энэ чинь энэ стратеги төлөвлөгөө энэ энэ чинь орж байгаа юм уу, орохгүй байгаа юм уу? Хууль хоорондын зөрчилтэй асуудлыг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Баасандорж дарга.

Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаатай уялдуулаад ер нь цаашдаа яах ёстой юм гэдэг талаас нь бас хариулт өг дөө. 5 Номер.

**Б.Баасандорж:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Байнгын хорооны дарга сая тогтоолтой холбоотой, үүрэгжүүлэгтэй холбоотой заалтыг хэллээ.

Ц.Сандаг-Очир гишүүний саяын хэлсэн агуулга бол манай зорилго 1 дээр зорилго, 2 дээр, стратегийн зорилго Ж.Бат-Эрдэнэ, 2 дээр яг үзэл санаа, үзэл баримтлалаараа суусан байгаа.

Мөн яг таны хэлдэг бол маш чухал асуудал. Яг энэ хууль хоорондын зөрчил, давхардал, хийдэлтэй холбоотой.

Тэгээд шат шатандаа хуулийн төсөл боловсруулахад хууль санаачлагчид маань яг энэ зөрчлийн асуудлыг хэрхэн яаж анхаарах вэ, өргөн мэдүүлэх түвшинд хэрхэн яаж анхаарах вэ. Хууль тогтоогчид буюу Улсын Их Хурал дээр батлагдахад Их Хурлын Тамгын газар эрх зүйн дүн шинжилгээ хийдэг энэ түвшиндээ яаж хамаарах вэ гэдэг асуудал бол маш чухал асуудал.

Яг энэ үүднээс Их Хурлын даргын захирамжаар гарсан Ажлын хэсэг дээр хуулийн давхардал хийдлийг арилгахтай холбоотой ажлын хэсэг ажиллаж байгаа.

Журмыг журамлахтай холбоотой ажлын хэсэг ажиллаж байгаа.

Мөн хамгийн чухал нэг асуудал бол Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр Хууль зүйн байнгынх хороон даргаар ахлуулсан ажлын хэсэг яг ийшээ онцгой анхаарч Ц.Сандаг-Очир гишүүн ээ, ахалж байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл манай энэ стратегийн хүрээнд Их Хурлаас одоо байгуулагдсан ажлын хэсэг, мөн стратеги батлагдсаны дараа ч гэсэн энэ 5 зорилгын хүрээнд ажлын хэсгүүд чиглэл чиглэлд Байнгын хороод, Байнгын хороодоосоороо гарч ажиллах байх гэж бодож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Батбаатар гишүүн асуултаа асууна.

**Б.Батбаатар:** Улсын Их Хурал бол нийт иргэн, сонгогчийн төлөөллийн төв болж төрийн эрхийг Үндсэн хуулийн дагуу барьж байгаа ийм байгууллага.

Тэгэхээр Их Хурал маань өөрөө Засгийн газар биш ард түмний төлөөллийн төв байгууллага гэдэг утгаараа тэр шинж чанараа хэр хадгалах юм бэ? Стратеги төлөвлөгөө дээр энэ чинь байгаа юм уу? Зорилгоо яаж тодорхойлж байгаа юм бэ?

Тэгээд тэр зорилгоо биелүүлэхийн тулд арга хэлбэр хийц, дотоод зохион байгуулалт, бүтэц энэ дээр ямар өөрчлөлт орох юм?

Яг үнэндээ Засгийн газарт байгаа 3 улс төрийн нам өнөөдөр Улсын Их Хурлын буюу ард түмний төлөөллийн төв байгууллагынхаа бүх эрхийг нь эдэлж байгаа шүү дээ.

Төсвийн зарлага гэж байна. Сая төсөв дээр баахан шүүмжлэл өрнөлөө.

Төсвийн зарлагын хяналтын хороон дарга нь Ардчилсан намаас. Хүний эрх ярьж байна. Хүний эрхийн дэд хороон дарга нь засагт хамтарч байгаа Хууль зүйн сайдтай Ардчилсан намаас.

Засгийн газарт сайдууд нь байгаа гамууд нь хяналтын чиг үүргүүдийг нь давхар хэрэгжүүлээд явах нь энэ чинь энэ стратеги төлөвлөгөөндөө нийцэж байгаа юм уу. Энэ чиглэлээр стратеги төлөвлөгөөнд юу орж байгаа юм?

Дээрээс нь Их Хурал ард түмний төлөөлөл гэдэг нэг шинж чанараас гадна хууль тогтоогч байгууллага. Хууль тогтоохдоо Үндсэн хуульд нийцүүлж хуулиа баталдаг. Үндсэн хуульд нийцүүлж чадаагүй хуулиа цэцийн дүгнэлтээр хүлээж авч өөрчилдөг, засварладаг.

Тэгэхээр хууль тогтоох үйл ажиллагаандаа хүний эрхийг хангана гэдэг зүйлүүд бүх хуульдаа хүний эрхийг хангана гэж байгаа юм.

Хүний эрхийг зөрччихсөн маш олон хуулийн зүйл заалтууд, журам дүрэм, тушаал шийдвэрүүд байгаад байдаг.

Иргэний Зориг ногоон намын мөрийн хөтөлбөрт Улсын Их Хурлын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрт Эрх чөлөөний тухай хууль батлуулна гээд байж байдаг.

Эрх чөлөөний тухай хууль гэдэг нь энэ хуульд нийцээгүй хууль Улсын Их Хурлаар батлагддаггүй байх тухай асуудал явагдана.

Тэгэхээр зарим ийм хуулиудыг стратеги төлөвлөгөөн дээр оруулж бид энэ энэ чиглэлийг ингэж хангахын тулд хүний эрхийг ингэж хангахын тулд хууль тогтоогч байгууллагынхаа хувьд ийм зүйлүүдийг хийнэ гэдэг тэр хуулийн нэр томъёо, зорилго, үзэл санаа, үзэл баримтлалыг оруулж стратеги төлөвлөгөөндөө оруулах боломж байхгүй юу?

Дээрээс нь Улсын Их Хурал өөрөө ийм нормчлогдсон байгууллага болж болохгүй.

Иргэдийн төлөөлөл гэдгийгээ бодох хэрэгтэй. Нийт иргэн сонгогчийн Монголын ард түмний төлөөлөл гэдгээ бодох хэрэгтэй.

Нормчлол тавьдаг, нормын ажил үүрэг гүйцэтгэдэг ийм Их Хурал байж болохгүй.

---



Энэ явж байгаа зүйлүүд чинь ер нь нэг нормын ажилчидтай юм шиг л ийм ч зүг рүүгээ хандлага нь яваад байна шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? Х.Булгантуяа дарга хариулъя.

**Х.Булгантуяа:** Б.Батбаатар гишүүний үндэс суурь нь ингээд байх шиг байна.

Одоогийнхоо хууль тогтоомжийн зохицуулалтаар хүрэх стратеги төлөвлөгөөгөө гаргах гээд байгаа юм уу, эсвэл стратеги төлөвлөгөөнийхөө хүрээнд хууль тогтоомжоо зарим зохицуулалтуудаа өөрчлөх юм уу. Тийм ээ.

Та олон ургалч үзлийг дэмжсэн, хяналт шалгалтыг сайжруулахын төлөө шаардлагатай бол Улсын Их Хурлын тухай хуулиа өөрчлөх юм уу, Дэгийн тухай хуулиа өөрчлөх юм уу гэдэг асуудлыг хөндөж байна гэж бид би ойлголоо.

Яах вэ манай ажлын хэсгээс бид өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд л бид үүнийг юу яаж гаргалаа.

Тэгэхдээ таны хэлж байгаа 3 нам өнөөдөр засагт хамтарчхаад төсвийн хяналтын асуудал яахаараа Ардчилсан намын гишүүнд байдаг юм байна гэдэг асуудал бол харамсалтай нь нөгөө Улсын Их Хурлын тухай хуульдаа тэгээд суулгаад өгчихсөн байсан. Тийм ээ. Б.Батбаатар гишүүн. Тухайн үед бид хэд бас энэ асуудлуудыг ярьж байсан.

Тэгэхдээ бид бол үүнийг эхлээд стратеги төлөвлөгөөгөө гаргачхаад, энэ стратеги төлөвлөгөөнд хүрэхэд өнөөдрийн хууль тогтоомжууд, ганцхан Улсын Их Хурлын, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль тогтоомж ч биш ер нь бусад хууль тогтоомжууд энэ хэрэгцээ шаардлагад хүрэхэд, зорилго зорилтод хүрэхэд шаардлагатай бол би өөрчлөх л ёстой гэж бодож байна.

Ажлын хэсгийн даргын хувьд.

Тэгэхдээ үүнийг би мэдээж ганцаараа шийдэхгүй л дээ.

Хуульд өөрчлөлт оруулах бол мэдээж нийт гишүүдийн саналаар л явдаг асуудал.

Тэгэхээр энэ зорилго зорилтдоо хүрэхийн тулд бид өнөөдөр урагшаагаа зарим нэг алхмуудыг бол хийх ёстой. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль байдаг юм уу бусад зарим нэг хууль тогтоомжид өөрчлөлт оруулж байж хүрэхээс өөр аргагүй байвал бид үүндээ хүрэхийн төлөө ажиллах л ёстой гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүн асуулт асууна.

---



**О.Номинчимэг:** Стратегийн төсөлтэй танилцлаа.

Нэлээн бас чухал нийгэмд хүлээлттэй байгаа асуудлуудыг хөндөж оруулж ирсэн байна.

Гэхдээ яах вэ бас нэг Улсын Их Хурлын өөрийн чиг үүргийг бодохоор хууль тогтоох, хянан шалгах, Улсын Их Хурлын гишүүд өөрөө дахиад төлөөлөх гэдэг ийм 3 чиг үүрэгтэй.

Тэгээд энэ үйл ажиллагааг бид яаж стратегитай тусгах вэ гэдэг дээр асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, бид нэгэнт Олон Улсын Парламентын Холбооны гишүүн.

Олон Улсын Парламентын Холбооноос ардчилсан парламентын индикатор гээд 7 зүйлээр нэлээн олон индикаторыг гаргасан байдаг.

Энэ улсын парламент ардчилсан парламент мөн байна уу гэдэг ийм индикатор байгаа.

Тэгэхээр энэ 7 индикатор үр дүнтэй байх, хариуцлагатай байх, ил тод байх, хариу үйлдэлтэй байх. Тийм ээ. Хүртээмжтэй оролцдог. Тэгээд төлөөлдөг гэсэн энэ үзүүлэлтүүд нь дотроо нэлээн задарч байгаа.

Энэ дээр ер нь манай Улсын Их Хурал ямар түвшинд байна, аль индикатор дээр нь бид илүү анхаарах хэрэгтэй байна гэдэг дүгнэлтийг ер нь хийсэн юм болов уу? Ер нь энэ ажил хийгдсэн юм болов уу гэдгийг нэгдүгээрт тодруулмаар байна.

Хоёрдугаарт, яах вэ, стратеги зорилгын 1-ээс эхлүүлээд ингээд харахаар ер нь нэлээн хууль тогтоох үйл ажиллагаа руу чиглэсэн юмнууд байх шиг байна.

Хууль тогтоох, ингээд судалгаатай байя судалгаан дээр тулгуурласан байя, энэ хүний эрх рүү чиглэсэн байя гэдэг хууль тогтоомж.

Гэтэл бид нарын түрүүн С.Бямбацогт гишүүн хэлж байна л даа.

2019-2024 онд энэ парламентын хийсэн гол нэг ажил Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг гаргаад Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг эхлэлийг нь суурийг нь маш сайн тавьсан.

Энэ мэдээж эхлэлийг нь дөнгөж тавьсан учраас энэ өөрөө улс энэ удаагийн парламентын үйл ажиллагаа нь бэхжиж, өмнө нь гарч байсан алдаа дутагдал байх юм бол үүнийгээ засаж өшөө илүү сайн хяналт шалгалтын механизмыг бий болгох ёстой гэж харж байгаа.

---

Тэгээд энэ чиглэлийн юм их дутмаг байгаа юм болов уу гэсэн үг юу байна.

Энэ дээр төлөвлөж байгаа асуудал, хийсэн юм байвал хэлж өгөөч.

Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд Улсын Их Хуралд гүйцэтгэх засаглалаа хянан шалгадаг.

Тэгтэл Засгийн газар өөрөө өөрийгөө бас хянан шалгадаг нэг бүтэц гараад ирчихсэн. Яг хэн нь хяналтын энэ механизмаа яаж явуулах гээд байгаа гэдэг нь бас тодорхойгүй байдал үүсээд байгаа юм бол байгаа. Тийм ээ. Хоёрдугаарт, энэ.

Гуравдугаарт, ардчилсан парламентын индикаторуудыг харах юм бол нэг бас чухал юм байгаа.

Бид нарт энэ парламентад иргэдийн итгэх итгэлийг яаж бид дээшлүүлэх вэ. Үндсэн хууль бид өөрчлөөд, холимог тогтолцоог оруулаад. Одоо ингээд тойргийн, жагсаалтын гээд өөр статустай ч гэж байх шиг иймэрхүү юмнууд явж байна.

Энэ бол ер нь л тангараг өргөсөн адилхан гишүүд. Тийм үү? Адилхан. Тэгээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн үр дүнг бид гаргахын төлөө энд гишүүд өөрсдөө.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүнд нэмэлт цаг өгье.

**О.Номинчимэг:** Гишүүд өөрсдөө хариуцлагатай хандах ёстой. Гишүүний нөгөө 3 чиг үүргээ маш сайн хийх ёстой.

Дээр нь энэ ардчилсан парламентын суурь үзүүлэлт индикаторууд дээр гишүүдийн хувьд авлига албан тушаалын асуудлаас хол байх, сонирхлын зөрчлөөс ангид байх, этик буюу ёс зүйн асуудлууд маш өндрөөр тавигддаг.

Тэгээд бид ч гэсэн үүнийгээ хамт дагуулж авч явж байж бид парламентад итгэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зөв байсан юм гэдэгт итгэх иргэдийн итгэлийг сайжруулна гэж бодож байна.

Зөвхөн хууль тогтоох чиглэлээр иргэд рүү чиглэсэн хүний эрх гэхээс гадна бусад чиг үүргийнхээ асуудлууд дээр.

Дээр нь гадагшаа чиглэхээс гадна дотоод парламентчдын өөрсдийн хариуцлагын асуудлаа ч гэсэн бас хөндөх ёстой юм бол болов уу гэсэн саналтай байгаа юм.

Тэгэхээр энэ дээр зорилтын энэ стратеги төлөвлөгөөнд юу юу орсон юм, дэлгэрүүлж болох уу гэдэг дээр бас хариулт авмаар байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 6 номер. 6 номерын микрофон.

---

**У.Хосжаргал:** О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Бид Олон Улсын Парламентын Холбоотой энэ стратеги боловсруулах дээр маш ойр хамтарч ажилласан.

Ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа гишүүн маань бас Ерөнхий нарийн бичгийн даргатай бол яг энэ үеэр хуралд явж бас уулзалтууд хийсэн байгаа.

Яг таны хэлдэг 7 индикаторын хүрээнд бид энэ жөндөрийн тэгш эрхийг хангах гээд ингээд маш олон саналуудыг бол Олон Улсын Парламентын Холбооноос 9 санал ирсэн. Тэгээд 6 саналыг нь бол бид тусгаж оруулж ажилласан байгаа.

Энэ дээр яг энэ парламентын хяналт хэрэгжүүлэлттэй холбоотой бас заалтуудыг тодотгож ирүүлснийг бид стратегийнхаа 2 дугаар стратегийн зорилгын 2.2 дээр бол Монгол Улсын Их Хурал хууль тогтоомжийг биелэлтэд хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ. Хууль тогтоомжийн үр нөлөөг судалж, үр дүнд үндэслэн хуулийг боловсронгуй болгоно гээд ингээд маш тодорхойгоор тусгаж оруулсан.

Мөн хяналт хэрэгжүүлэхдээ энэ дата анализыг ашиглаж нийгэмд гарсан үр нөлөөг тооцно гээд ингээд маш дэлгэрэнгүйгээр тусгаж оруулсан байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? Хариулт. Х.Булгантуяа гишүүн.

Ажлын хэсэг дахиж хариулах уу? Өөр асуултауд байгаа юм байна шүү дээ.

6 номер. Хянан шалгах үйл ажиллагаатай холбоотой асуулт.

**У.Хосжаргал:** Эхний асуулт бол, О.Номинчимэг гишүүний эхний асуулт бол 7 индикатор дээр манайх ямар байгаа вэ гэдэг үнэлгээ асуусан. Тийм ээ.

Тэгэхээр бид 7 индикатор дээр бол яг манайх тэддүгээр байранд байна гэдэг үнэлгээ бол байхгүй байгаа. Яг энэ 7 индикатор дээр туссан ардчилсан парламент байна уу гэдэг дээр тулгуурласан стратеги хийгдсэн учраас энэ дээр бол жөндөрийн эрхийг хангах, тэгш байдал, оролцоо гээд 9 санал олон улсын парламентаас ирүүлснийг бид 6-г нь тусгаад оруулаад явсан байгаа.

Хоёр дахь асуулт бол Улсын Их Хурлын функцэд байдаг хяналт шалгах процессыг хэрхэн сайжруулах вэ гэдэг асуулт байсан.

Тэгэхээр энэ асуулт дээрээ бол бид стратегийнхаа 2 дугаар зорилтын хүрээнд 2.2 дээр бол маш тодорхой тусгаж өгсөн.

Үүнийг та бүхэнд уншиж танилцуулъя. Монгол Улсын Их хурал хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ. Хууль тогтоомжийн үр

нөлөөг тогтмол судалж үр дүнд үндэслэн хууль боловсронгуй болгож хэвшинэ гэж ингэж тусгасан байгаа.

Гуравдугаар асуулт болохоор ёс зүйтэй холбоотой асуулт байсан. Парламентын гишүүдийн ёс зүйг хэрхэн яаж тусгасан бэ гээд.

Тэгэхээр бид яг энэ үнэт зүйлийн 4 дүгээр зүйл дээр бол ёс зүйтэй, хариуцлагатай хариуцан тайлагнадаг гэж онцгойлон тус тусгаж өгсөн.

Үүнийг манай ажлын хэсгийн С.Эрдэнэболд гишүүн маш ач холбогдол өгч тусгасан байгаа.

Эргээд хариуцан тайлагнадаг гэдэг механизм алга гэдэг ийм үндэслэлээр бол энэ хариуцан тайлагнах тайлагнах ёстой гэдгийг тусгасан тусгаж оруулсан байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? С.Эрдэнэболд гишүүнд нэмж хариулъя.

**С.Эрдэнэболд:** Ер нь энэ стратеги төлөвлөгөө гэхээр ийм юм билээ.

Одоо ажлын хэсгийнхэн ч гэсэн бас хэлж байсан. Би бид нар, ажлын хэсгийнхэн хэд хэдэн удаа нэлээн нямбай чамбай хуралдахыг хичээсэн.

Тэгээд яг энэ парламентын засаглал хөгжихсөн, парламентэт ёс хөгжсөн орнуудад ийм стратеги төлөвлөгөө гэж бол байхгүй.

Бодит байдал нь.

Манай улсын хувьд яаж байна гэхээр ийм шилжилтийн үеийн бас байгаад байгаа. Нөхцөл байдал нь.

Яагаад ингэж хэлж байгаа юм бэ гэхээр Улсын Их Хурлын даргын хэлээд байгаа үг бол 803 хууль, 2 мянга илүү журам, хуулийн үйлчлэлээ давсан журам. Тэр нь бол олон янзын хүний эрхийн зөрчилтэй гээд ийм статистик бол хэлээд байгаа.

Түрүүн бас Ц.Сандаг-Очир гишүүний асуугаад байгаа аягүй зүйтэй асуулт байгаа юм.

Тэгэхээр ер нь 2024-2028 оны парламентын гол зорилго бол энэ хүн төвтэй үзэл гэдэг хүн төвтэй энэ шалгуурыг тавья гэдэг зүйл яриад байгаа.

Тэгээд бид ажлын хэсэг дээрээ олон ч удаа маргалдсан, хэлэлцсэн, ярилцсан. Нийт экспертүүдийн дунд хэлэлцүүлэг эд нар зохион байгуулсан.

Ер нь энэ хүн төвтэй гэдгээ бид яаж тодорхойлох гээд байгаа юм бэ гэдэг дээр маш их акцент өгсөн юм.

Эдийн засгийн утгаараа юу гэсэн үг юм, эрх зүйн утгаараа юу гэсэн үг юм, нийгэм соёлын утгаараа юу гэсэн үг юм. Тэгээд энэ бүх зүйл л нь өөрөө Улсын Их Хурлын шийдвэр гаргалт, бодлого дээр очоод ямар хэмжүүр дээр очих юм бэ гэдэг талаасаа нэлээн их ярилцсан юм.

Тэгээд энэ яг ингээд хүн төвтэй үзэл гэдгийг тодорхойлчихсон тодорхойлолт бас тэр болгон түгээмэл тийм тодорхойлолт байхгүй байгаад байгаа юм.

Тэр утгаараа бид энэ дээр яг ингээд философи талаас нь, эрхийн философи талаас нь, хэл зүй талаас нь, эдийн засаг талаас нь, эрх зүй талаас нь, ингээд тал талаас нь бас ингээд мэргэжилтнүүдийн санаа оноог сонсоод ер нь хүн төвтэй байдал шийдвэр гаргалт нэг иймэрхүү байх юм байна гэдэг томъёоллийг л энэ дээр оруулах гэж хичээсэн байгаа юм.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын шийдвэр гаргалтын бүх процесст энэ хүн төвтэй байна гэдэг хүний эрх, эрх чөлөөгөө дээдэлсэн, тэр хүний хэрэгцээ шаардлага энэ бүх зүйлүүдээ тэргүүн эрэмбэ нь байсан гэдэг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахиад С.Эрдэнэболд гишүүнд 1 минут сунгаж өгье.

**С.Эрдэнэболд:** Нөгөө талаасаа түрүүн Х.Булгантуяа даргын хувьд энэ Төрийн байгуулалтын байнгын хороо жил болгон энэ дээр хөтөлбөр гаргана гэж хэлж байгаа.

Түүний өмнө талд нь юу гэхээрээ энэ стратегийн баримт маань өөрөө шалгуур үзүүлэлт болох ёстой гэж бид тийм бодлогыг баримталсан.

Одоо жишээлбэл, Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх бол төсөв батлах. Тэгэнгүүт төсөв дээр яадаг вэ гэхээр аудит дүгнэлт гаргана гэж байдаг. Гаргадаг. Гэтэл Аудитын газраас үндэсний аюулгүй байдлын үзэл баримтад нийцүүлж хянах ёстой гэж хэлдэг. Гэтэл тэрийгээ хийж чаддаггүй. Яасан гэхээр хэмжих нэгж байхгүй гэдэг шалтгаанаар энэ хяналтаа аудит гаргаагүй байх жишээтэй.

Тэгэхээр ер нь энэ Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрүүд дээр ер нь бүгдээрэн дээр нь жигд энэ хүн төвтэй үзэл гээд байгаа зүйл, энэ хүний эрхийг хангах болон бусад ийшээ чиглэсэн зүйлүүд дээрээ энэ стратегийн бичиг баримт маань өөрөө шалгуур үзүүлэлт болох юм байна гэдэг тэр томъёолол дээр бид ажлын хэсэг ажилласан гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс гарч байгаа оновчтой саналуудыг аваад бас тусгагдаагүй гэж харж байгаа саналуудаа бас энэ төсөл дээр бид ингээд багт.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Би нэг асуулт бас асуучихъя.

Энэ ийм байгаа юм. Сая С.Эрдэнэболд гишүүн ч бас хэллээ. Олон улсын парламент дээр бас нэг тийм олон кэйс бол байхгүй байгаа юм байна шүү дээ. Тийм ээ.

Тэгээд бид Улсын Их Хурлын тухай хуульдаа хуулийн 4.8 дээр Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр нэг стратеги төлөвлөгөөтэй байгаад ингээд явах зайлшгүй л хэрэгцээтэй болчихоод байгаа юм л даа.

Тэгэхээр энэ маань сая гишүүд Ц.Сандаг-Очир гишүүн ч хэллээ, бусад гишүүд хэллээ. Хүрэх үр дүнтэй, хариуцлага тооцох тодорхой механизмтай байх ёстой л гэж байгаа юм. Яах вэ үүнийгээ бид суулгаад оруулаад ирж байгаа юм.

Тэгээд сая С.Бямбацогт гишүүнийг хамгийн эхнийх дээр асуулт асуугаад байсан. Миний бас бодож байсан зүйлийг л хэлээд байгаа юм л даа.

Бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан. Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад олон намын тогтолцоотой болсон. Энэ бол онцгой Их Хурал гэж үзээд байгаа шүү дээ.

Үүнээс хойш бид Үндсэн хуулиараа холимог тогтолцоотой олон намын олон нам орох ийм боломж бололцоог хангасан ийм Их Хурал цаашдаа үйл ажиллагаа явуулж байгаа. Урьд өмнө олонх цөөнх гэдэг л ганц л зүйл байлаа шүү дээ.

Ер нь тийм үү. Ардын нам, Ардчилсан нам л гээд л явж байсан байх.

Тэгэхээр одоо энэ дотор С.Бямбацогт гишүүний бас нэг асуугаад байгаа асуулт энд. Яг энэ олон намын тогтолцоо энэ ер нь ямаршуу байдлаар суух ёстой юм бэ? Суусан юм уу?

Би энд хараад байна л даа. 4 дэх зорилт дээр олон ургалч үзэл бүхий дэвшилтэт шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ гэхчигсэн байгаа байхгүй юу. Энэ дотор эсвэл олон намын тогтолцоо гэдэг зүйлээ бас нэг оруулах юм уу? Үүнийг үзэх хэрэгтэй шүү дээ бид нар.

Энэ удаагийн парламент 5 нам орж ирсэн. Тийм үү. Нам эвсэл орж ирсэн шүү дээ. Энэ онцгой тохиолдол. Цааш цаашдаа яг ингэж явна. Энэ нь өөрөө ардчилал бий болгох хамгийн том механизмыг бид Үндсэн хуульдаа хийж өгсөн.

Хоёрхон нам хоорондоо үзээд байдаг байсан бол одоо 5 нам энэ парламентад доор ороод олон ургалч үзлийг энд жинхэнэ бэхжүүлж байгаа ийм парламент байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр нэг жоохон тодруулах хэрэгтэй юм уу гэсэн нэг зүйл л харагдаад байгаа юм. Надад. Ажлын хэсэг юу гэж бодож байна. Ийм үг үсэг бас байх хэрэгтэй юу. Ямар утга агуулга оруулах нь зүйтэй юм гэсэн нэг тийм өнцгөөс нэг хариулж өгөөч.

Х.Булгантуяа дарга.

**Х.Булгантуяа:** Стратегийн зорилгын 4-д та түрүүн хэлж байна.

Олон ургалч үзэл бүхий дэвшилтэт шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ гээд.

4.1 дээр нэг дээр Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаанд олон ургалч үзлийг хөхиүлэн дэмжиж, цөөнхийн саналыг хүндэтгэн олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг бэхжүүлж, гишүүд төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлнэ гээд.

Бид яг нам, эвслээр нь хуваагаад аваад яг ярихаар бас жоохон хэцүү байгаад байгаа юм. Нэг нам дотор ч гэсэн хүмүүс нь өөр өөр үзэл санаатай санаатай байгаад байгаа байхгүй юу.

Цөөхөн гишүүнтэй нам хүртэл өнөөдөр бүлэг байгуулах хэмжээнд биш байгаа ч гэсэндээ 4 гишүүнтэй өнөөдөр нэг нам ч гэсэн хоорондоо 4 өөр үзэл санаатай байхыг бид үгүйсгэхгүй.

Тэгэхээр өнөөдөр сая төсвийн хууль дээр гэж байхад Ардын намын зарим гишүүд нь өөр санаа бодолтой, Ардчилсан намынх нь бас өөр. ХҮН намаас гэхэд 8 хүнээс нь 3 нь эсэргүүцээд 4 нь, 5 нь дэмжээд байх шиг байгаа юм.

Тэгэхээр ийм байж байгаа цаг үед бол яг нам, эвслээр нь гэж хэлэхээс илүүтэйгээр энд бол бид өөр өөр сегментийг төлөөлж байгаа, өөр өөр орон нутгуудыг төлөөлж байгаа. Зарим нь нийслэлийн дүүргүүдийг. Зарим хөдөө орон нутгуудыг ингээд төлөөлж байгаа. Зарим нь бол яг салбарын төлөөлөл болж орж ирж байгаа гэдэг утгаар нь харна уу гэхээс биш яг нэг хуучин шигээ яг намаар, эвслээр гэдгээр нь бас олон ургалч үзэл гэдгийг хайрцаглах нь учир дутагдалтай юм байна гэж бодож л олон ургалч үзэл гэж арай ерөнхий байдлаар бичиж оруулж өгсөн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Минийхээр ажлын хэсэг буруу бодож байна шүү.

Бид парламентад сонгуульд орохдоо яасан билээ. Бүгдээрээ хувь хувиараа орж ирээгүй биз дээ. Намаар нэр дэвшиж орж ирсэн шүү дээ, намын бодлогоор орж ирсэн шүү дээ, намын мөрийн хөтөлбөр боловсруулж орж ирсэн шүү дээ.

Тэр мөрийн хөтөлбөрийг чинь ард иргэд сонголтоо хийсэн байхгүй юу. Түүнээс хувь хүмүүсээр нь сонголт хийгээгүй шүү дээ.

---



Тийм болохоор энэ парламент дотор энэ намын бүлэг, одоо энэ Батын Батбаатар дарга гэх гэх мэтчилэн энэ гишүүдийн, энэ нөгөө эвсэл юуны дарга нарын энэ бүлгийн хэсэг гишүүдийн юу гэдэг юм, нам эвслийн бодлого бол уг нь зайлшгүй орж байх ёстой юм шүү дээ.

Ер нь зарчим нь бол энэ шүү дээ. Бид сонгуульд орохдоо нам, эвслээр орж ирсэн.

Одоо тэгээд бид нэг нам гэхээр айгаад байдаг болчихлоо л доо.

Нөгөө төрийн дээр нам гарчихлаа гэдэг үгнээсээ айсаар байгаад бид энэ намыг дурдахаас айдаг болчихлоо. Ингэж болохгүй л дээ.

Бид нарын зарчим намаараа энэ чинь сонгуульдаа орж байгаа зарчим шүү дээ. Нам бодлого гаргаж байгаа. Нам улс эх орныг хөгжүүлэх мөрийн хөтөлбөр стратеги бодлогоо гаргаж ирж өрсөлдөж байгаа шүү дээ.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу?

С.Бямбацогт гишүүн, С.Зулпхар гишүүн, О.Алтангэрэл гишүүнээр тасаллаа. С.Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Тэгэхээр энэ 2024-2028 оныхоо стратеги төлөвлөгөөг нэлээн сайн нухацтай хэлэлцэх л хэрэгтэй л юм шиг санагдаад байгаа юм л даа. Урьд өмнөх үеүдээс парламентад бас нөхцөл байдал нэлээн өөр болчихсон гэдгийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт жагсаалтаар гишүүд сонгогддог болсон.

Үүнтэй холбоотойгоор цөөхөн намын төлөөлөл орж ирдэг байсан бол олон намын төлөөлөл орж ирдэг болсон байна. Илүү юу гэдэг юм төрийн бодлого, намын бодлого, бүлгийн шийдвэр гэхээсээ илүү хувь хүнийхээ улс төр хийдэг болсон байна.

Тэгээд энэ үедээ ямархуу байдлаар ямар стратеги төлөвлөгөөтэй байж энэ төрийг төр шиг байлгах вэ, энэ төрийн бодлого тодорхойлох төрийн эрх барих дээд байгууллагад ард түмэн төлөөлж байгаа төлөөллийн мандат хангагдах вэ гэдэг дээр бас нэлээн сайн бодохгүй бол мордохын хазгай болчих вий л гэж хэлээд байгаа шүү дээ.

Тэгээд орж ирж байгаа төсөл маань ерөнхийдөө тийм бэлгэдлийн шинж чанартай, тунхгийн шинж чанартай, хэмжигдэхүйц зорилго хүрэх үр дүн харагдахгүй байгаад байдаг. Гэтэл өнөөдрийн парламент маань урьд өмнөх парламентуудаас илүү өөр онцлог нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулж байна. Явуулах юм шиг байна. Цаашдаа бас тийм. Улам л тийм л болох байлгүй дээ.

---



Тийм болохоор түүндээ таарсан, түүндээ яаж дасан зохицдог стратеги зөв чиглүүлэх вэ.

Бид стратеги. Стратеги гэдэг чинь бол ерөөсөө л одоо бид ямар зорилгод хүрэх гэж байгаа, тэр зорилгодоо хүрэх арга зам, замын зураглалаа тодорхойлох гэж байгаа.

Тэгээд 2028 онд парламент маань ингээд ард түмний итгэлийг хүлээчихсэн, ард түмэн алга ташуулчихсан ийм зөв бодлого тодорхойлоод зөв үйл ажиллагаа явуулаад зөв парламент ард түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн ийм байх юм сан.

Парламентын засаглал маань улам бэхэжсэн, улам тийм үү, чадавхажсан байх юм сан гэдэг рүү чиглэсэн стратеги тодорхойлчихоод, замынхаа зураглалыг тодорхойлчихоод, түүн рүү чиглүүлсэн үйл ажиллагаа явуулах ийм юмыг л бид сайн хийж авахгүй бол ер нь бол нэг тийм жоохон замбараагүйдүү л байгаад байна шүү дээ.

Энэ өнгөрсөн сая төсвийн хэлэлцүүлгүүдийг харж байгаа байх тийм үү. Ерөөсөө л олонх цөөнх гэж байхгүй, сөрөг хүчин байгаа ч юм шиг, байхгүй ч юм шиг эрх барьж байгаа нам нь эрх бариад байгаа ч юм шиг үгүй ч юм шиг.

Тэгээд үүнийгээ бид бас нэг зөв болгож явахгүй бол эцэст нь Их Хурлын гишүүдээр дамжаад л энэ төр л муухай харагдана.

Тэгээд л хамар доор хагархай байна ч гэдэг юм уу гишүүн болчихоороо л ерөөсөө л хаа хамаагүй юм ярьдаг, дуугардаг, ярьдаг болох ёстой юм байна, мод болох ёстой юм байна, тод болох ёстой юм байна, моод болох ёстой юм байна гээд бодчихдог. Тэгээд дуугараад байдаг. Тэр чинь эцэстээ эргээд энэ төрийн нэр хүндийг унагааж байгаа, эцэст нь төрд итгэх ард түмний итгэлийг л алдаж байгаа шүү дээ.

Тийм болохоос төрийн төрийн залгамж чанар байх ёстой. Төрд бас бодлого байдаг юм. Энэ парламент чинь бас ийм онцлогтой үед ингэж үйл ажиллагаа явуулаад, эцэстээ ард түмэнд хүлээн зөвшөөрөгдөөд ард түмнээ алга ташуулаад, талархал нь хүлээгээд, ингээд төрийг бас зөв удирдаад чиглүүлэх ёстой хүмүүсийн нэгдэл юм шүү. Ийм бодлоготой, зорилготой хүмүүс ажиллах ёстой юм шүү гэдэг зарчим үнэт зүйлтэй л болгосоор байна л даа.

Тэгэхгүй ерөөсөө л өнөөдөр дуугарч л байвал, ялгарч харагдаж л байвал чухал гэдэг байдал чинь хэр зөв юм бэ? Энэ дээр л би бас бүгдээрээ бас бодох юм сан.

Тийм болохоор Их Хурлын стратеги гэдэг юмаа ажлын хэсэг байгуулаад энэ дээр нэлээн анхаарч ажиллаад, үүнийгээ тийм үү өшөө яаж зөв болгохын төлөө явах вэ гэдэг дээр нэг жоохон анхаарчхаасай л гэж хүсье.

---

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Ажлын хэсгийнхэнд юуны өмнө бас талархсанаа илэрхийлье. Бас энэ амаргүй ажил.

Ялангуяа хууль тогтоох одоо жишээ нь засаглалыг хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурлын стратеги шинэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд бий болсон сонгуулийн үр дүнгээр зохион байгуулагдсан парламентын үйл ажиллагаатай уялдуулсан байдлаар боловсруулах бол бас амаргүй байсан байх. Гэхдээ нэг зүйлийг бид бол бас ойлгох ёстой.

Ер нь парламентын ч бай, улсын бусад төрийн эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг, эрх мэдэл хуулиар зохицуулагдсан байгаа.

Бид бол Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуулиас давж ямар нэгэн байдлаар парламентыг шинэ парламент болгох ийм зорилт бол тавиагүй.

Харин энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд манай парламент энэ 4 жилд яаж ажиллах юм, магадгүй зарим нэг сорилтууд байгаа. Тэр сорилтоо яаж давах юм.

Тэгэхдээ тэрийг зохион байгуулалтын түвшинд яаж давах юм, магадгүй жишээ нь тодорхой чадавхаар бэхжүүлэх чиглэлээр яаж давах юм, шинжлэх ухаан, технологийн, инновацын ололтыг яаж нэвтрүүлэх юм гэдэг ийм л зүйлийг энд босгосон ийм нэг стратегийн баримт бичиг.

Улсын Их Хурал бол өөрөө байгуулага. Байгууллага болгон жишээ нь стратегийн баримт бичигтэй байж болно. Тэр үүднээс хийж байгаа зүйл гэж ойлгох ёстой.

Гэхдээ сая С.Бямбацогт гишүүний хэлдэг бас үнэн. Бид бол мэдээж хэрэг 126 гишүүнтэй парламент болчихсон учраас, түүнээс гадна холимог, тогтолцоогоор байгуулагдсан парламент учраас, түүнээс гадна сонгуулийн үр дүнгээр бас тодорхой засаглалын хэв маягууд бий болж байгаа учраас үүнтэй уялдсан зарим нэг сорилт байгаа.

Тэр сорилтыгоо бид давахгүйы бол явцад нь бидэн түүнээс хийсэн, түүнээс жишээ нь багагүй тийм сорилтууд гарч магадгүй. Энэ үүднээс бол энэ стратеги бол үүнийг зохицуулах ёстой гэж ойлгож байна.

Яг үүнтэй уялдсан байдлаар бид сая нөгөө О.Номинчимэг гишүүн хэлж байна.

Бид Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийг баталчихсан. Одоо энэ хэрэгжилт хангагдаад явж байгаа.

Энэ бол бидэнд бол бас шинэ томоохон жишээ нь зорилт. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бид яах юм бэ гэдэг энэ зүйл бол бас энд орох ёстой.

Та бүхэн зорилго 2 дотор бол зорилго 2.1 2 болгож оруулсан байна лээ. Энэ сайн байх.

Түүнээс гадна ер нь зүгээр энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурал өөрөө бас бүтцийн тодорхой нэгжүүдтэй. Тэр нь юу гэх дээр зэрэг Тамгын газар бүлэг, түүнээс гадна Байнгын хороод, гишүүдийн зөвлөх болон туслахууд тэдгээрийн чадавхыг бас яаж бэхжүүлэх юм бэ гэдэг бас ажил энд бол тусгагдах ёстой байх гэж бодож байгаа юм.

Энэ байгууллагын хувьд бол тэгж л цааш явдаг учраас энэ үүднээс нь бол харах ёстой байх гэж бодож байна.

Нөгөөтээгүүр мэдээж хэрэг бид энэ стратегийг боловсруулаад хэрэгжүүлэх явцад та бүхэн сая тайлбар хийж байна.

Бид жил болгон тухайлсан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах юм гэж. Тэр бол зөв.

Хэрвээ үйл ажиллагааны төлөвлөгөө нарийвчилж гарахгүй бол энэ стратеги бол бүхэлдээ бидэнд нэг ёсондоо зүгээр нэг ийм бичиг баримт шиг л болчихоод байна л даа.

Үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг тодорхой ажлуудыг яаж хийх юм, үүнтэй холбоотой ямар хүн хариуцах юм, ямар байгууллага хариуцах юм. Эндээс ямар үр дүн гарах вэ гэдгээ шалгуураар нь тооцчихсон үр дүнг нь урсаад тооцчихсон ийм зүйл байх ёстой учраас үүнийг заавал хийх ёстой. Их Хурлын Тамгын газар өөрсдөө үүнийг бол хариуцаж хийж бас үүнийг танилцуулах юм байна гэж ойлгож байна.

Тийм учраас энэ дээр бид бол бас яах вэ тодорхой зүйлүүдээр бол зарчмын зөрүүтэй санал хураалгаад бас явах ба байх. Бусад Байнгын хороодоор, бас чуулганаар хэлэлцээд бол энэ баримт бичгийг бол цааш нь явуулах нь зүйтэй байх гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Алтангэрэл гишүүн үгээ хэлнэ.

**О.Алтангэрэл:** Бас энэ бичиг баримтыг боловсруулсан ажлын хэсэгтээ баярлалаа гэж хэлье.

Тэгээд бид яах вэ, харахад ингээд нэг хэдэн үг өгүүлбэр хэлхэгдсэн байгаа мэт боловч бас яг суугаад бичье гээд хийхээр амаргүй байдаг.

Зүгээр би сая ярьсан асуудлуудтай холбогдуулаад хоёр зүйлийг гишүүддээ мэдээллийн чанартай тодруулаад хэлчихье гэж бодсон юм.

Манай Д.Амарбаясгалангийн даргын хэлсэн тэр 800 гаруй хүний эрхийн зөрчилтэй заалт гэж Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй шүү.

Энэ бол нэг судалгааны байгууллагын одоогоос 3, 4 жилийн өмнө хийсэн судалгааны тайланд дурдагдсан л нэг тоо.

Тэгээд үүнийг ингэж хэдүүлээ ялгаа заагийг нь гаргаж байхгүй бол энэ хүний эрхийн чиглэлийн индекс гаргахад оролцдог олон улсын байгууллагууд, хүний эрхийн активистууд дандаа ийм тоог төрийн хариуцлагатай албан тушаалтны амнаас гарсан тоог ашигладаг.

Тэгээд Монгол Улс хүний эрх, эрх чөлөөний индексээр ухраад байгаагийн цаана бол яг ийм хариуцлагагүй тоонууд, хариуцлагагүй жишээнүүд байдаг гэдгийг анхааруулж хэлье.

Яг үнэндээ хүний эрхийн зөрчилтэй заалт тэд эд байна гэсэн нарийн тоо бол алга.

Тэгэхээр энэ дээр бол тэр 800 гаруй гэдэг ч. Байхыг бол үгүйсгэхгүй. Тэгэхдээ тэр 800 гаруй гэдэг ч юм уу ийм тоо бас хэрэглэхгүй байхыг хүсэж байна.

Нөгөө талаар бидний манай Их Хурлын дарга санаачлаад нэг зөв зорилт тавьсан. Энэ журмаар буюу захиргааны хэм хэмжээний актаар нийгмийн харилцааг зохицуулдаг байдлыг өөрчилье гэдэг ийм асуудал тавьж байгаа. Энэ бол зөв.

Тэгэхдээ захиргааны хэм хэмжээний акт буюу өнөөдөр Монгол Улсын хэмжээнд Хууль зүй, дотоодын хэргийн яаманд бүртгэлтэй байгаа 2600 гаруй журам, захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомж болгоно гэдэг нь өөрөө нэлээн ажилтай ярвигтай ийм ажил байгаа юм.

Бид сая татвар, тэгээд нийгмийн хамгаалал, хууль зүй, байгаль орчин, уур уурхай гэсэн энэ 5 салбарт энэ ажлуудыг ер нь хийж хэрэгжүүлбэл яах вэ гээд нэг жилийн төлөвлөгөө гаргасан. Жил бол барахааргүй байгаа юм. Бараг 2 жил бүрэн бүрэлдэхүүнээрээ суугаад 200 гаруй журам байхгүй болох юм билээ.

Тэгээд ер нь энэ хэм хэмжээний акт, журмыг байхгүй болгоно гэдэг нь тэр журмыг аваад нэг хууль дээр бичих асуудал бас биш байгаа юм.

Дахиад эрх зүйн зохицуулалтыг үндсээр нь судлах, шинэ шинээр хууль бичиж байгаа юм шиг хандах ийм их нүсэр ажил байгаа юм шүү.

Тэгээд та бүхэн маань энэ стратегийн зорилтот төлөвлөгөөнд дурдсан, бас Их Руурал дээр яригдаж байгаа энэ ажил бол бас нэлээн төвөгтэй бөгөөд маш их ажил орох ийм чухал ажил байгаа юм шүү гэдгийг цааш цаашдынхаа үйл ажиллагаанд бас ойлгож хандахыг хүсье.

Тэгээд ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд үг хэлж дууслаа.

Зарчмын зөрүүтэй санал С.Зулпхар гишүүн гаргасан байна.

Саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурал стратеги, зорилт, зорилго 2

Монгол Улсын Их Хурал үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжсэн цаг үеийн шаардлага, нийгмийн амин чухал эрэлт, хэрэгцээг тооцсон цогц шийдвэр гаргана гэсэн нь байсныг “гаргах, институцийн чадавхыг бэхжүүлнэ” гэсэн байна. Мөн үү? Тайлбар хэлэх үү?

Х.Булгантуяа дарга тайлбар хэлье. Ажлын хэсгийн дарга.

**Х.Булгантуяа:** С.Зулпхар гишүүний гаргаж байгаа санал бол зөв өө.

Бид энэ удаагийн бас стратеги төлөвлөгөөг нөгөө 60 орчим хувь нь эсрэгээрээ, 60, 70 хувь нь гадагшаагаа чиглэсэн байхад илүү их зорилго тавьсан.

Стратеги 2 бол бид нарын хувьд цаг үеийн шаардлагад Монгол Улсын Их Хурлаас гаргаж байгаа шийдвэрүүд нь заримдаа нийцэхгүй байна. Эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байна. Цогц шийдвэр болж чадахгүй байна. Язгуур заримдаа сонирхлыг дээдэлж, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжиж чадахгүй байна гэсэн шүүмжлэлүүд манай судалгаагаар гарсан учраас бид ийм шийдвэр гаргана. Энэ бол бид нарын хувьд нэг зорилго нь.

Ингэхийн тулд гээд 2, 3 зорилтыг тавьсан байж байгаа. Үүн дээр сая манай Ц.Сандаг-Очир гишүүн бас хуулийн хийдэл, зөрчлийг арилгаж байж цаг үеийн шаардлага, нийгмийн амин чухал эрэлт, хэрэгцээг тооцон шийдвэр гаргана шүү гэж.

Энэ бол гадагшаагаа чиглэсэн манай шийдвэр бол ийм байна шүү гэсэн зорилт.

Харин ийм шийдвэрүүдийг гаргахын тулд стратегийн зорилго 4 нь тэгвэл манай парламентын үйл ажиллагаа ийм байж бэхжиж байж ийм чиглэлээр үйл ажиллагаа явуулж байж дээдлэх 3 стратегийн зорилгоо биелүүлэх юм шүү гэсэн

дотогшоогоо чиглэсэн. Сүүлийнх нь болохоороо дотогшоогоо чиглэсэн байна гэж томилсон юм байж байгаа юм.

Тэгэхээр дээд талын хамгийн сүүлийнх нь 4 дэх нь бол олон ургалч үзэл бүхий дэвшилтэт шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ гэдэг нь бол бидний дотоод үйл ажиллагаандаа баримтлах.

Энэ нь бол энд ийм парламент бэхжиж байж дээд талын 3 зорилго биелэх юм гэж бас үзэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Зулпхар гишүүн гаргасан саналаа тайлбарлая.

**С.Зулпхар:** Х.Булгантуяа гишүүн. Баярлалаа. Их тодорхой тайлбар хийж байна.

Ер нь ойлголт бол нэг байна. Гэхдээ яах вэ миний гаргасан санал бол хэл найруулга, утга зүй талаасаа эхний тэр найруулгыг уншихаар зэрэг алдаатай санагдаад байгаа учраас хийсэн тайлбар юм.

Эхнийхийг уншихаар ингээд байгаа байхгүй юу.

Одоо “нийгмийн амин чухал эрэлт хэрэгцээг тооцсон цогц шийдвэр гаргана” гээд.

Их Хурал ямар шийдвэр гаргах тухай ингэж өгүүлбэр уншигдаад байгаа юм. Их Хурал яаж шийдвэр гаргахыг Үндсэн хуулиар, Улсын Их Хурлын тухай хуулиар тодорхойлоод ингээд зохицуулчихсан байгаа юм.

Тэгэхээр би дахиад нэг ийм зохицуулалтыг стратеги дотор ингэж оруулж ирэх нь нэг талдаа буруу байх ойлгож байгаа юм.

Хоёрдугаарт, таны хэлсэн зүйлтэй санал нэг байгаа юм. Энэ гадагшаа чиглэсэн бай, дотогшоо чиглэсэн бай, аль алиныг нь илэрхийлсэн байдлаар илэрхийлсэн байдлаар институцийн чадавх л чухал.

Зохион байгуулалт байх ёстой, тодорхой хэм хэмжээ байх ёстой, тодорхой үйл ажиллагаа байх ёстой, харилцаа байх ёстой гээд.

Тэгэхээр зэрэг миний оруулж байгаа санал бол тэр институцийн чадавх гэдэг дотор чинь шийдвэрээ яаж гаргах тэр сорилтууд байгаад байна шүү дээ. Тэр сорилтыг давах найруулга нь байгаа учраас шийдвэр гаргах институцийн чадавхыг бичүүлье гэж ингэж найруулъя гэсэн ийм санал оруулж байгаа юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Түрүүний миний уншиж танилцуулсан С.Зулпхар гишүүний стратегийн зорилт 2-т орсон өөрчлөлтийг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

---

46.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Стратегийн зорилт 3.

Монгол Улсын Их Хурал гэсэн байсныг Их Хурлын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшлийг бүрэн нэвтрүүлнэ.

Дэвшлийг дэмжинэ гэсэн байсныг бүрэн нэвтрүүлнэ гэсэн юм байна.

Х.Булгантуяа гишүүн тайлбар хийе.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийнх нь найруулга дээр нь бас юу яагаадхаарай.

Улсын Их Хурлын үйл ажиллагаанд гэдэг нь бол зүйтэй байх. Тэр найруулга нь бол зөв байх.

Зүгээр шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшлийг бүрэн нэвтрүүлнэ гэдэг бол их хэцүү шүү дээ.

Өнөөдөр бид арай гэж нэг юм нэвтрүүлж байтал нэг шинэ юм гарч ирээд л маргааш тэр чинь нөгөө iPhone араас хөөцөлдөөд бардаггүйтэй адилхан юм болчих билүү гэсэн тийм юу байна.

Дээрээс нь нэмээд бид бас өөрсдийнхөө энэ үйл ажиллагаанд бид анх эхлээд нэвтрүүлнэ гэж бичсэн юм.

Тэгсэн чинь нэвтрүүлнэ гэхээр бид өөрийнхөө үйл ажиллагаанд л ганцхан нэвтрүүлэх болчихоод байгаа юм.

Түүнээс гадна бид Улсын Их Хурлаас гаргаж байгаа бодлого шийдвэр нь үүнийг бас дэмжих ёстой.

Одоо бусад Засгийн газрын төрийн байгууллагууд, хувийн хэвшилд улс эх орны хөгжил шинжлэх ухаанч байдлыг дэмжих хууль эрх зүйн орчныг бид бий болгох ёстой гэсэн үүднээсээ ганцхан нэвтрүүлнэ гэдэг нь бас дотоод руу чиглэжээд байна. Энэ бол гадагшаага болон дотогшоогоо гэдэг утгаараа бид “дэмжинэ” гэж оруулж өгсөн юм.

Тэгээд Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаандаа гэх үү. Тийм ээ.

Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаанд гэх үү.

6-аас найруулга дээр нь нэг зөв найруулаад. Одоо санал хураалт явах гээд байгаа учраас.



**Ж.Бат-Эрдэнэ:** С.Зулпхар гишүүн тайлбар хийх үү? Шууд явчих уу? С.Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Тэр Улсын Их Хурлын үйл ажиллагаанд гэдэг нь гарцаа байхгүй тэгж бид найруулах ёстой.

Их Хурал хэрвээ технологийг дэвшинэ гэвэл энэ тэртээ тэргүй Их Хурлын өөрийнх нь үндсэн чиг үүрэг шүү дээ.

Бодлогыг боловсруулж хуулиа батлахтай холбоотой тэгж уншигдаад байгаа юм.

Сүүлийн би харин Х.Булгантуяа гишүүний саналтай бас санал нэгдэж байна. Сүүлийн өгүүлбэрийг бол харин бүрэн нэвтрүүлнэ гэдэг бол бас жоохон өрөөсгөл болчих учраас үйл ажиллагаандаа шинжлэх ухаан, технологийн дэвшлийг жишээ нь дэмжинэ гэж таны таны оруулсан тайлбар байсан шүү дээ.

Түүгээр, “дэмжинэ” гэдгээр байж болох байх гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Наадах чинь ингэх юм байна шүү. Үгүй үгүй. Нэвтрүүлнэ байхгүй юу даа. “Бүрэн” гэдгийг нь хасчихъя.

“Дэвшлийг дэмжинэ” биш. “Дэвшлийг нэвтрүүлнэ” болох уу?

Х.Булгантуяа дарга.

**Х.Булгантуяа:** С.Зулпхар гишүүн ээ, урд талынх нь ч гэсэндээ бас болохоо байчхаад байгаа юм биш.

Манай ажлын хэсгийнхнээс бас ингэж байна. Улсын Их Хурал энэ шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшлийг зөвхөн өөрийнхөө үйл ажиллагаанд нэвтрүүлэхээс гадна манай гаргаж байгаа хууль тогтоомжууд нийт Монгол Улсад үүнийг нэвтрүүлэхийг дэмжих ийм хууль эрх зүйн орчныг бий болгоно гэж зорьж байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал үйл ажиллагаандаа гэх юм бол бид ганцхан дотоодынхоо.

Энэ нэг санал хураалгах төхөөрөмж, бичиг цаас ч байдаг юм уу. Тийм ээ. Нөгөө оффис 360-ыг нэвтрүүлэх л ажил болчихоод байгаа юм.

Хэрвээ бид үүнийг дэмжинэ гэх юм бол манайхаас гарч байгаа, Улсын Их Хурлаас баталж байгаа хууль тогтоомж, бодлогын бичиг баримтууд үүнийг дэмжсэн. Өөртөө ч болон бусдад ч гэсэндээ дэмжсэн ийм.

---



Нэвтрүүлнэ гэхээр уг нь бол бид ямар хувийн хэвшилд бол нэвтрүүлнэ гэхэд бол хэцүү шүү дээ. Хувийн хэвшлийг бол бид дэмжсэн эрх зүйн орчныг бий болгох л асуудал болчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр Байнгын хорооны дарга энэ эхнийх нь найруулга нь зөв болчхоод байх шиг байх юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хураалт. /алх цохив/

15-аас 2 гишүүн санал өгч, 13.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Саналын томьёолол.

Монгол Улсын үйл ажиллагааны Монгол Улсын Их Хурлын үнэт зүйлс хэсэгт нэмэлт.

1.Иргэдийн оролцоог хангах. Энэ өөрчилж байгаа юм уу, эсвэл нэмэлт үү.

Нэмэлт оруулж байгаа юм уу?

Улсын Их Хурлын үнэт зүйлс хэсэгт.

1.Иргэдийн оролцоог хангах.

С.Бямбацогт гишүүн тайлбараа хий. Гаргасан саналаа тайлбарлая.

**С.Бямбацогт:** 2019 оны Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний үнэт зүйлст байсан зарчим л даа.

Аль бол болох иргэдийн оролцоог хангаж ажиллая гэж.

Тэгээд хуучин байсан нөгөө иргэдийн оролцоог хангах гэдэг зүйлийг авчихаар бас иргэдийн оролцоо хангахаа болих гэж байгаа юм байна. Ерөөсөө иргэдээ сонсохгүй юм байна гээд нэг мушгидаад явчих вий.

Ер нь бол иргэдийн оролцоог хангаж байж ард түмний засаглах эрхийг эрхийг бид хангана, биелүүлнэ.

Тэгэхээр энэ агуулгаар үүнийг оруулаад явчихвал нэг их илүүдэхгүй болов уу л гэж бодоод явж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Бямбацогт гишүүний гаргасан Улсын Их Хурлын үнэт зүйлс хэсэгт иргэдийн оролцоог нэмэх гэж оруулсныг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

46.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

---

Энэ уг нь байвал байхаар л санал байлаа даа уг нь.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан дараагийн санал.

Монгол Улсын Их Хурлын үнэт зүйл хэсэгт.

2.Хамтын шийдвэрээ хүндэтгэх гэж нэмэх юм байна. Тийм үү.

Түрүүний санал дээр О.Алтангэрэл гишүүн дэмжсэнээр гээд.

Тэгвэл горимын санал гаргачих. О.Алтангэрэл гишүүн өөрөө горимын санал гаргачих. О.Алтангэрэл гишүүн.

**О.Алтангэрэл:** Саяын санал хураалт дээр дэмжсэн санал өгөх гээд дарсан боловч амжсангүй. Тэгээд дэмжсэнээр тооцож өгөөч ээ. Төхөөрөмж ажиллахгүй байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Алтангэрэл гишүүн дэмжсэн ч төхөөрөмж ажиллаагүй тул санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна.

Ингээд санал хураалт явуулъя. Түрүүний явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалт. Дахин санал хураалт.

66.7 хувиар С.Бямбацогт гишүүний гаргасан санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал. Монгол Улсын Их Хурлын үнэт зүйл хэсэгт “хамтын шийдвэрээ хүндэтгэх” гэж нэмэх.

Санал тайлбар хэлэх үү? С.Бямбацогт гишүүн тайлбар хэлье.

**С.Бямбацогт:** Энэ Их Хурлын үнэт зүйлс хэсэг дээр би нэмэх гэж байгаа юм.

“Хамтын шийдвэрээ хүндэтгэх” гээд.

Тэгээд ер нь Их Хурал бид чинь нэг л айл шүү дээ. “Дуугарвал дуу нэг, дугтрвал хүч нэг”. Бас “нэр нэгтийн чих нэг”. “Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино” гээд олон ургалч үзэлтэй. Шийдвэр гаргахдаа ажлын хэсэг дээрээ, бүлэг дээрээ, Байнгын хороо, чуулган дээр бүгдээрээ л эсрэг тэсрэг байр

сууриа илэрхийлдэг, чөлөөтэй мэтгэлцдэг. Энэ бол байх ёстой. Бие биеэ чөлөөтэй шүүмжилдэг. Ил гараад ярьдаг. Энэ байх ёстой.

Нэгэнтээ тэгээд Улсын Их Хурал шийдвэр гаргасан бол, төрийн хууль тогтоомж батлагдсан бол, нэгэнтээ олонх нь ингээд зөв гаргасан бол түүнийгээ бүгдээрээ биелүүлдэг, түүнийгээ хүндэтгэдэг байхгүй бол нөгөө “дээрээ гүйдлээ олохгүй доороо суудлаа олохгүй” гэж бид Их Хурал өөрөө баталсан хуулиа хэрэгжүүлэхгүй, Их Хурлын гишүүд нь өөрсдөө олонхын шийдвэр батлагдсан хууль дүрмээ мөрдөхгүй байх юм бол доошоогоо тэгээд л ард түмэн асуудал тэгээд л нөгөө хуулиа би биелүүлдэггүй байж, мөрддөггүй байж гэдэг болох байх л даа.

Тийм болохоор нэгэнтээ л маш сайн мэтгэлцээд. Нөгөө “бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэж ярьдаг. Түүнтэй адилхан олон талаас нь шүүмжилье, олон талаас нь мэтгэлцье, хойшлуулъя.

Ингэж байгаад асуудал нэгэнтээ шийдэгдээд олонх болоод хууль тогтоомж батлагдсан бол түүнийгээ буруу хууль батлагдчихлаа, буруу шийдвэр гарчихлаа гээд ард түмнээ талцуулж хуваагдуулаад тогтворгүй байдал үүсгээд яваад байхгүй энэ дээрээ нэг байдаг байвал яасан юм бэ.

Тийм үүднээсээ бас Их Хурлын гишүүд ухамсартай үүргээ ойлгодог байгаасай гэдэг үүднээс л хамтын шийдвэр. Нэгэнт нэгэнт тийм үү. Маш сайн ярилцаад.

Тэгэхгүй хүч түрээд гэдэг юм уу, мэдэгдэхгүй, мэдээлэл дутуугаас буруу зөрүү шийдвэр гаргах асуудлууд байдаг.

Сая төсвийн хэлэлцүүлгийн явцад үндсэндээ тиймэрхүү юмнууд болсон. Түүнээс болоод үл ойлголцол үүссэн.

Тэгэхээр үл ойлголцол үүсэхгүй тийм үү, аль болох сайн ярилцъя, хэлэлцье, мэтгэлцье. Ингээд эцэст нь бүгдээрээ итгэл үнэмшлээрээ шийдвэрээ гаргасан бол түүн дээрээ л.

Төр байхгүй бид чинь төрийн эрх барих дээд байгууллага шүү дээ. Хууль тогтоох.

Тэгээд энэ төр нь төр шиг байхгүй тэгээд л гараад л зарим нь гаргасан шийдвэрээ үгүйсгээд байдаг болчих юм бол энэ төр тогтворгүй болох, энэ ард түмэн чинь талцаж хуваагдах энэ юмны чинь эхлэл болчих байх.

Тийм болохоор л хамтын шийдвэр хүндэтгэх гэдэг зарчим бас Их Хурлын гишүүн болгон эрхтэй, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Мэдээж тийм үү.

Гэхдээ нөгөө талдаа бас энэ төрийн тогтвортой байдал, төрийн залгамж чанар, энэ төрийн бодлого шийдвэр хэрэгжих гэдэг дээр бид бас манлайлах бас тодорхой үүрэгтэй байх ёстой.

Зөвхөн эрхээ эдэлдэг биш үүргээ биелүүлдэг байх гэдэг үүднээс энэ хамтын шийдвэрээ хүндэтгэх гэдэг бас үнэт зүйл бидэнд байх ёстой шүү л гэдгийг оруулчихъя гэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэрэггүй байх аа. Ажлын хэсэг, санал гарсан хоёроос нь л санал авчихъя.

Ажлын хэсэг 5 номер. Тайлбар хэлэх үү?

**Б.Баасандорж:** С.Бямбацогт гишүүний саналыг зарчмын хувьд гишүүн ээ, ойлгож байна.

Гэхдээ энэ үнэт зүйл дээр орж болохгүй байх аа. Яг стратеги зорилго 4 дээр уг нь энэ санаа, агуулга нь байгаа байхгүй юу. Жишээ нь, “олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг бэхжүүлж” гээд.

4 дэх зорилго маань нөгөө шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ, олон ургалч үзлийн дэвшилтэт шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр яг саяын С.Бямбацогт гишүүний хэлсэн хамтын шийдвэрийг хүндэтгэх гэдэг яг энэ санаа бол олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг бэхжүүлж гэдэгт байгаа байхгүй юу. Яг энэ зүйл, энэ зорилго 4 дээр байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Бямбацогт гишүүний Монгол Улсын Их Хурлын үнэт зүйлс хэсэгт “хамтын шийдвэрээ хүндэтгэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

13.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Ц.Сандаг-Очир гишүүний гаргасан санал байна.

Стратеги зорилгын зорилт 2.3-ын “шаардлагыг” гэснийг “шаардлага, хуулийн хийдэл, зөрчлийг” гэж өөрчлөх.

Саналаа тайлбарлах уу? Ц.Сандаг-Очир гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

40 хувиар санал дэмжигдсэнгүй. Санал уналаа.

О.Номинчимэг гишүүний гаргасан санал.

---

Стратеги зорилт 2-ын 2.2 дээр “хяналт тавих” гэсний дараа “Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж” гэж нэмэх.

Тайлбар уу? О.Номинчимэг гишүүн тайлбар хэлье. Санал дээрээ.

**О.Номинчимэг:** Яах вэ, энэ томьёолол нь нөгөө хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх гэгчсэн байгаа юм.

Тэгээд хууль тогтоомжоос гадна Улсын Их Хурлын шийдвэрүүд байна. Хүний эрх чөлөөг хангахтай холбоотой асуудлууд байна. Өөрөө хянан шалгах чиг үүрэг илүү өргөн хүрээтэй.

Тэгэхээр энэ дээр нэмээд “Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн тогтолцоог илүү бэхжүүлэх” гэдэг энэ үгийг л нэмчихье гэж байгаа юм.

Тэгээд өргөн цар хүрээтэй сонгол, томилгоо. Хянан шалгах чиг үүрэг бол албан тушаалтныг томилохоос авхуулаад, хуулийн хэрэгжилт, төсвийн хяналт гэх мэтчилэн олон төрөл байгаа учраас зөвхөн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих гэхээс илүүтэй ерөнхий нэр томьёог нэмчихье гэсэн ийм санал гаргаж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Монгол Улсын Их Хурал хурал хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих” гэсний дараа Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг бэхжүүлэх тогтолцоог бэхжүүлж.

Тогтолцоог бэхжүүлэх гэж байгаа юм байна шүү. Өөр үг орж ирж байна. Тийм үү? Хянан шалгах чиг үүрэг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж гэж байна шүү дээ.

Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хянан шалгах чиг үүргийг гэж орж ирж байгаа юм уу?

О.Номинчимэг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

15-аас 7 гишүүн.

О.Алтангэрэл гишүүн горимын санал.

**О.Алтагэрэл:** Санал өгөх гэсэн ёстой нөгөө улаан юм маань гараад ирчихсэн байна. Ажилладаггүй. Зөндөө оролдлоо. Саналаа өгч чадсангүй. Хүчингүй болгоод дахиж явуулж өгнө үү гэсэн хүсэлт байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Төхөөрөмж ажилласангүй. Саналыг хүчингүй болгож өгнө үү гэсэн санал гаргаж байна.

---

Саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.3 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүйд тооцогдлоо.

Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Санал дууссан уу? Гаргасан саналуудыг санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Ингээд “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд ээ. Анхааралтай. Санал хураалт явуулъя.

15 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Сүүлийн саналыг Э.Болормаа гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглээрэй.

Ингээд хэлэлцэх эсэх асуудал дууссан тул өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал өндөрлөснийг мэдэгдье. Амжилт хүсье.

**Хуралдаан 1 цаг 45 минут үргэлжилж, 16 цаг 04 минутад өндөрлөв.**

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**ЦАЛТАН-ОД**